



ДУУРГИЙН ЖИШИГ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ОНЦЛОГ,
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ



АНАГААХЫН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТӨГСӨЛТИЙН
ДАРААХ СУРГАЛТЫН ЧАНАРТ ГАРСАН АХИЦ ӨӨРЧЛӨЛТ



МОНГОЛД ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХАД ОРУУЛСАН ДЭМЖЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН

САЛБАРЫН

ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР 4,4+ ТӨСӨЛ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



MONGOLIA
ADB@30



Partnering
Developing
Innovating



Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4+ төсөл

Номын мэдээллийг эмхэтгэж, агуулгыг боловсруулсан: Д.Гэрэлт-Од

Номыг хянан тохиолдуулсан: А.Мөнхтайван - НТХН-н Зохицуулагч

Н.Оюунбилэг - ЭМСХХ-4, 4+ төслийн дэд зохицуулагч

Ш.Оюунбилэг - Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт шинжилгээ,
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Алтанцэцэг - Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүний нөөц, төлөвлөлт,
зөвлөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Номыг эрхлэн гаргасан: АХБ-ны санхүүжилттэй Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр - 4, 4+ төсөл

Анхны хэвлэл

Улаанбаатар хот 2021 он

ISBN:

© Энэхүү номын агуулгыг зөвхөн төслийн мэдлэг, мэдээллийг түгээх хүрээнд
ашгийн бус зорилгоор ашиглаж болно.

Дизайнер: Б.Санаа



Төслийн зорилго:

Эрүүл мэндийн салбарын үр өгөөжийг дээшлүүлэн, эмнэлгийн засаглал, бие даасан байдал болон эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

Энэхүү номонд
АХБ-ны санхүүжилттэй
Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4, 4+ төсөл
хэрхэн амжилттай хэрэгжсэн тухай өгүүлнэ.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР
ТАЛАРХАЛ

18

ЭНЭ ТӨСӨЛ ЯАГААД ХЭРЭГЖИХ БОЛОВ?

АХБ Монголд

АХБ ба Эрүүл мэндийн салбар

Төсөл хэрэгжихийн өмнөх Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээ

26

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР - 4, 4+ ТӨСӨЛ

Төслийн зорилго

Төслийн тодорхойлолт

Төслийн санхүүжилт

Төслийн хүрээнд хийгдсэн гэрээ

34

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

Улаанбаатар хотын эмнэлгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө
боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Хөрөнгийн төлөвлөлтийн тогтолцоо

СХДНЭ-ийн багийн чадавхижуулалт

Хүний нөөцийн чадавхижуулалт

Сувилахуйн зөвлөх үйлчилгээ

СХДНЭ-ийн бүтэц, зохион байгуулалт

Олон нийтийн онооны картын аргыг нэвтрүүлсэн нь

Тохиолдсон бэрхшээл, түүнийг даван туулсан арга зам

Анхны санаа

Яагаад Сонгинохайрхан дүүрэгт гэж?

СХДНЭ-ийн барилгын ажлын үйл явц

Төслийн эхний ажил

Барилгын ажлын зураг

СХДНЭ-ийн барилга угсралт
Барилгын дэд ажлын хэсэг
Автозогсоолын газар чөлөөлөлт
Газар чөлөөлөхтэй холбоотой бэрхшээл
СХДНЭ-ийн автозогсоол, нэмэлт зам, гүүр, орц гарц
СХДНЭ-ийн тоног төхөөрөмж
СХДНЭ юугаараа жишиг эмнэлэг болов?

110

**ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН 2: ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ
БЭХЖҮҮЛЭХ**

118

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ**

128

ТӨСЛИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

130

СУРГАМЖ

122

ТӨСЛИЙН ҮР АШИГ ХҮРТЭГЧИД

ЭМСХХ-4, 4+ ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

142

ТАЛАРХАЛ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

МОНГОЛ ТОВЧЛОЛ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
ГССҮТ	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НАЗХГ	Нийслэлийн Авто Замын Хөгжлийн Газар

НЕТГ	Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний Газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар
НХХЯ	Нийгмийн Халамж, Хөдөлмөрийн Яам
НЭМГ	Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
ОНОК	Олон Нийтийн Онооны Карт
СХД	Сонгинохайрхан Дүүрэг
СХДЖНЭ	Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг
СХДНЭ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТУХ	Төслийн удирдах хороо
ТЭЗҮ	Техник Эдийн Засгийн Үндэслэл
УИХ	Улсын Их Хурал

УСАГ	Ус Суваг Ашиглалтын Газар
ХӨСҮТ	Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
ХСҮТ	Хавдар Судлалын Үндэсний Төв
ЦССҮТ	Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв
ЭМДС	Эрүүл Мэндийн Даатгалын Сан
ЭМСХХ	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

АНГЛИ ТОВЧЛОЛ

ANAB	American National Accreditation Body Америкийн Үндэсний Магадлан Итгэмжлэлийн Байгууллага
ECRI	Emergency Care Research Institute Яаралтай Тусламжийн Судалгааны Институт
GMP	Good Manufacturing Practice Үйлдвэрлэлийн Зохистой Дадал
GDP	Good Distribution Practice Түгээлтийн Зохистой Дадал
GPP	Good Pharmacy Practice Эмийн Зохистой Дадал
JCI	Joint Commission International Олон улсын хамтарсан комисс
MSDNS	Management Sciences for Health Эрүүл мэндийн удирдахуйн ухаан
UMDNS	Universal Medical Device Nomenclature System Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн олон улсын нэр томъёо, кодын систем

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй мянга мянган эмч, эмнэлгийн ажилтнууддаа Монгол улсад орчин цагийн анагаах ухаан үүсч хөгжсөний 100 жилийн ойн халуун мэндийг хүргэе.

Эрүүл мэндийн салбар өнөөгийн түвшинд хүрч хөгжихөд донор орнууд, ДЭМБ, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд үнэлж баршгүй туслалцаа, дэмжлэг үзүүлж ирсэн. Ялангуяа сүүлийн 30 жилд эрүүл мэндийн салбарт томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж байгаа Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

АХБ-ны бүх талын туслалцаа дэмжлэгтэйгээр 1991 оноос эхэлсэн Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр төслүүд нь салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, хамтран ажилласныг дурьдахад таатай байна.

Үүний нэг тод илрэл нь 2013-2021 оны хооронд хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4, 4+” төслийн хүрээнд Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхижуулах, эмийн аюулгүй байдлыг улс даяар сайжруулах гэсэн 3 үндсэн

зорилтыг амжилттай хэрэгжүүллээ.

Цаашид энэ амжилтандаа суурилан манай салбар нь 2019-2029 онд хэрэгжүүлэх “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” олон шатлалт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4, 4+ төслийг амжилттай хэрэгжүүлэхэд оролцсон, хамтран ажилласан бүх оролцогч талууд, АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар болон захирал П.Рамачандран, түүнчлэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хамт олонд талархал дэвшүүлье!



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЭНХБОЛД

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-тай сүүлийн 30 жилийн хугацаанд үр дүнтэй хамтран ажиллаж байгаа Монгол улсын Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн салбарын хамт олонд Монгол улсад орчин цагийн анагаах ухаан үүсч хөгжсөний 100 жилийн ойн баярын мэнд хүргэе.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд, АХБ Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжиж, тогтолцооны бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлсээр ирсэн бөгөөд 2020 оны эцсийн байдлаар 3.6 тэрбум долларын зээл, буцалтгүй тусламж, техникийн туслалцааг Монгол улсын Засгийн газарт зориулан баталсан байна. АХБ-ны дэмжлэг нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, байгаль орчин, банк санхүү, эрчим хүч, зам тээвэр, хот байгуулалт, хөдөө аж ахуй зэрэг олон салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн.

АХБ нь 1993 оноос хойш Монгол улсад эрүүл мэндийн тогтолцоог шинэчлэхэд туслалцаа үзүүлж ирсэн хамгийн том олон талт хөгжлийн түншүүдийн нэг юм. Иргэдэд хүрэх эрүүл

мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нь АХБ-ны Монгол улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тууштай зорилт байсаар ирлээ. Бид эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний шинэчлэл, эмнэлгийн салбарын шинэчлэл, салбарын засаглал, эм, эмийн бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааны шинэчлэл, эрүүл мэндийн даатгалын нэвтрүүлэлт, эрүүл мэндийн дэд бүтэц, хүний нөөцийн хөгжил зэргийг хамруулан эрүүл мэндийн тогтолцоог цогцоор нь шинэчлэх, бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4, 4+ төслөөр Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд олон улсын стандартад нийцсэн дүүргийн нэгдсэн эмнэлгийг Сонгинохайрхан дүүрэгт барьж, ашиглалтанд орууллаа. Тус эмнэлэг нь үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэх, олон улсын эмнэлгийн стандартыг хангасан Монголын анхны дүүргийн эмнэлэг бөгөөд амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр

дотор, эх барих, эмэгтэйчүүд, мэс засал, гэмтэл, хүүхэд, хавдарын оношилгоо эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлэх юм. Түүнчлэн, эмнэлгийн барилга болон зураг төслийн шийдэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийн хувьд дүүргийн жишиг эмнэлэг болж чадсан. Төслийн хүрээнд цаашлаад эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх болон эмийн аюулгүй байдлыг сайжруулах ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ.

Энэхүү төсөл маань Монгол улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам, төслийг хамтран хэрэгжүүлсэн бүх байгууллага, эмнэлгүүдийн удирдлага болон эмч мэргэжилтнүүд, төслийн багийн уйгагүй зүтгэл, нягт хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжиж дууслаа. Та бүхэнд талархал илэрхийлж, амжилт хүсье.



*АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ МОНГОЛ УЛС
ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ*

П.РАМАЧАНДРАН

Монгол улсын Засгийн газар АХБ-тай хамтран ажилласны 30 жилийн түүхэн тэмдэглэлт ой энэ онд тохиож байна. Энэ хугацаанд АХБ-наас Монгол улсын эрүүл мэндийн салбарт өгч буй зээл, буцалтгүй тусламжийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байдагт бид талархдаг.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төсөл нь 2013-2021 оны хооронд амжилттай хэрэгжиж дууслаа. Энэ төслийн хүрээнд дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг барих, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, эмийн аюулгүй байдлыг сайжруулах гэсэн 3 үндсэн зорилтыг амжилттай хэрэгжүүллээ.

Монгол улсад анх удаа орчин үеийн чанар стандарт, аюулгүй байдлыг хангасан барилга байгууламж, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи бүхий чадварлаг хүний нөөцтэй орчин үеийн олон улсын эмнэлгийн стандартад нийцсэн 47 сая ам.долларын өртөг бүхий, Улаанбаатар хотын захын хорооллын 150,000


хүнд үйлчлэх хүчин чадалтай 250 ор бүхий Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилгыг барьж, бүрэн тоноглож ашиглалтанд орууллаа.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхижуулах зорилтын хүрээнд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын эрхзүйн орчинг шинэчилж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, 4 үндсэн мэргэшлийн резидентын сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгож, турших ажлыг амжилттай зохион байгуулж нийт 141 хүнийг төрөлжсөн мэргэшлээр сурган, олон улсад ашиглагддаг 4 гарын авлагыг орчуулж, хэвлэн гаргалаа.

Эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилтын хүрээнд Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг шинэчлэн боловсруулж, УИХ-аар батлуулах, эм хангамжийн байгууллагуудын дагаж мөрдөх үндсэн шаардлага буюу стандартуудыг шинэчлэн боловсруулж, Стандарт Хэмжил Зүйн Газрын Үндэсний

зөвлөлөөр батлуулах, Эмийн хяналтын лабораторийг шинэчлэх, ISO/IEC 17025:2005 стандартын дагуу олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх, Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартуудыг шинэчлэх, үндэсний эм үйлдвэрлэгчдийг батламжлуулах, эмийн зах зээлийн дараах тандалт, фармаковижилансын үйл ажиллагаа, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх тогтолцоог сайжруулах, эмийн аюулгүй байдлын засаглалыг бэхжүүлэх, эмийн салбарын ажилтнуудыг чадавхижуулах зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ.

Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд идэвхи чармайлт гарган хамтран ажилласан АХБ-ны Суурин төлөөлөгчийн газрын хамт олон, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, НЭМГ, СХДНЭ, АШУҮИС зэрэг газруудад талархал дэвшүүлье.



**НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ
НЭГЖИЙН ЗОХИЦУУЛАГЧ**

А.МӨНХТАЙВАН

ЭНЭ ТӨСӨЛ ЯАГААД ХЭРЭГЖИХ БОЛОВ?

АХБ МОНГОЛД



Ж.АЛТАНТУЯА

*АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын
Нийгмийн салбар хариуцсан ахлах мэргэжилтэн*

Энэхүү түүхэн номыг бүтээх цаг үетэй зэрэгцэн Азийн хөгжлийн банк Монгол улсад төсөл хөтөлбөр санхүүжүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлж, хамтран ажилласны 30 жилийн ой тохиож байна. Монгол улс АХБ-ны гишүүн орноор 1991 онд элссэн. Түүнээс хойш АХБ өнөөг хүртэл Монгол Улсын хамгийн гол, олон талт хөгжлийн түнш байгууллага байсаар ирсэн бөгөөд зах зээлийн эдийн засагтай, дундаж орлоготой улс орон болон хөгжихөд нь чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Монгол улсад АХБ-ны санхүүжилттэй төсөл хэрэгжихэд, Монгол улсын Засгийн газар хүсэлт тавьж, хүсэлтийн дагуу АХБ-ны мэргэжилтнүүд судалгаа хийн, улмаар төслийн баримт бичгийг боловсруулж, түүнийгээ АХБ болон Монгол улсын Засгийн газар, УИХ-аар батлуулах үе шатыг туулдаг. Төслүүдийг Монгол улсын Засгийн газар хэрэгжүүлдэг, харин АХБ санхүүжүүлэгчийн хувьд төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилладаг зарчимтай.

АХБ-ны 1991 оноос эхлэлтэй энэхүү хамтын ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсад зориулан нийт 2.7 тэрбум ам.долларын засгийн газрын зээл, 182.2 сая ам.долларын хувийн хэвшлийн зээл, 323.7 сая ам.долларын буцалтгүй тусламж болон 178.6 сая ам.долларын техник туслалцааны төслийг тус тус баталж хэрэгжүүлсэн.¹

АХБ БА МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

АХБ нь 1993 оноос хойш Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог өөрчлөн шинэчлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн хөгжлийн томоохон түнш юм. Монгол улсын эрүүл мэндийн салбар нь ЗХУ-ын загвар дээр суурилсан, хэвтүүлэн эмчлэхэд голлон анхаардаг олон эмнэлэг бүхий нүсэр тогтолцоотой байв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлд шилжих явцад Монгол улс хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, өндөр чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, тогтвортой бөгөөд үр дүнтэй эрүүл мэндийн тогтолцоог бүтээн байгуулж эхэлсэн юм.²

Монгол улсын эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн АХБ-ны санхүүжилттэй анхны төсөл 1994 оноос эхэлсэн түүхтэй бөгөөд Монгол улсад эрүүл мэндийн даатгалын тогтолцоог цоо шинээр бий болгоход мэргэжлийн зөвлөмж өгч, үндэсний чадавхийг бий болгоход чиглэсэн техник туслалцааны төсөл байв. Тухайн үед буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засаг руу шилжихтэй зэрэгцэн ЗХУ-ын дэмжлэг зогссоноор Монгол улсын төсөв эрүүл мэндийн салбараа санхүүжүүлэх боломжгүй болсон юм. Тиймээс, нэгд, эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр бий болгох, хоёрт, хувь хүний эрүүл мэнд өөрөөс нь хамааралтайг ойлгуулж, хариуцлагыг ухамсарлуулж, үүрүүлэх зорилгоор нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бий болгох хүсэлтийг Монгол улсын засгийн газар АХБ-д тавьснаар энэ төсөл эхэлсэн түүхтэй.

Монгол Улс 1994 онд эрүүл мэндийн үндэсний албан журмын даатгалыг нэвтрүүлж, улмаар эрүүл мэндийн үйлчилгээг оновчтой болгох, чанарыг сайжруулах, төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх, хүн амын санхүүгийн тогтвортой

1 АХБ-ны гишүүн орны танилцуулга. 2020.05

2 Монголын эрүүл мэндийн салбарын баримтын хуудас. 2021.05

байдлыг дээшлүүлэх зорилт тавьсан. 1995 онд АХБ-наас Монгол Улсын эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлсэн анхны техникийн туслалцааны төслийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын бодлогын орчинг сайжруулж, эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлэх үндэсний чадавхыг бэхжүүлсэн.

Дараа дараагийн техникийн туслалцааны төслүүд нь эрүүл мэндийн даатгалын тогтолцооны илүү нарийн асуудлууд болох даатгалын засаглал, төлбөрийн арга хэрэгсэл, худалдан авалт болон гэрээ хийх чадавх, даатгалын байгууллагын удирдлага, зохион байгуулалт зэргийг оновчтой шийдвэрлэхэд анхаарчээ. Хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх үүднээс эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажил хийгдсээр байна. АХБ-наас хэрэгжүүлсэн төслүүд нь эрүүл мэндийн салбарт "нэг худалдан авагчийн" тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын, бүтэц, үүрэг хариуцлага, удирдлагын тогтолцоо зэрэг асуудлуудыг цэгцэлж тодорхой болгоход дэмжлэг үзүүлж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн зардлын ангилалаар хийж байсан бол одоо анхан шатны тусламж үйлчилгээг нэг хүнд ноогдох төлбөрийн аргаар, харин эмнэлгийн тусламж үйлчилгээг өртөг

ойролцоо оношийн бүлгээр тооцох тогтолцоог нэмж нэвтрүүлээд байна. Үр дүнд суурилсан эдгээр төлбөрийн аргуудыг нэвтрүүлснээр эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахыг зорьж байна.³

Үүний дараа буцалтгүй тусламжийн болон зээлийн төслүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлж ирсэн. 1998 онд буюу эрүүл мэндийн салбар нэг тогтолцооноос нөгөө тогтолцоо руу шилжиж тогтолцооны томоохон өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй байсан тэр л үед Эрүүл Мэндийн Салбар Хөгжил Хөтөлбөр (ЭМСХХ)-1 төсөл батлагдсан бөгөөд тулгараад буй асуудлыг өргөн хүрээ, том зургаар харж хийсэн нэг том ажил нь өрхийн эрүүл мэндийн тогтолцоог бий болгосон явдал байв. Ханиад хүрэх, халуурах гэх мэт эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг өрхийн эрүүл мэндийн тогтолцоо 2000 оноос өмнө Монгол улсад байгаагүй бөгөөд хот суурин газруудад өрхийн эрүүл мэндийн төвүүдийг байгуулахыг АХБ анх санаачилсан юм. Мөн хөдөө орон нутгийн сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, анхан шатны, нэн шаардлагатай тусламжийг Монгол улсын иргэнд ойртуулж, хаана ч байсан,

санхүүгийн дарамтгүйгээр авах нөхцөлийг бүрдүүлэхэд том хувь нэмэр оруулсан билээ.

Дараагийн төсөл болох ЭМСХХ-2 төслийн гол зорилго нь орон нутаг дах ядуу, эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, мөн өмнөх төслийн санаачилан эхлүүлсэн эрүүл мэндийн салбарын чадавхи, үр ашиг, тогтвортой байдлыг бэхжүүлж, салбарын шинэчлэл, хөгжлийг үргэлжүүлэхэд чиглэж байв. Төсөл Баянхонгор, Дорнод, Хэнтий, Өвөрхангай, Завхан аймгуудад хэрэгжсэн. Эдгээр төслүүдийн үргэлжлэл болох ЭМСХХ-3 төсөл нь Архангай, Дундговь, Говь-Алтай, Сүхбаатар, Төв аймгууд болон Улаанбаатар хотын ядуу, эмзэг бүлгийн хүн ам ихтэй хоёр дүүргийн 700,000 гаруй иргэдэд хүрэх анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулан, хөдөө, хотын хоорондох эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн ялгаатай байдлыг бууруулах зорилго тавьсан. Төслийн хүрээнд эмнэлгийн барилга байгууламж барих, дэд бүтцийг сайжруулах, орчин үеийн тоног төхөөрөмж нийлүүлэх болон эрүүл мэндийн ажилтнуудыг сургах зэрэг олон ажил хийгдсэн.

Төслийг хэрэгжүүлэхдээ олон нийт, оролцогч талуудын оролцоог хангасан нь шинэлэг бөгөөд үр дүнтэй алхам болсон юм. Энэ төслөөр

эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой болгох, бодлогын баримт бичгүүд болон холбогдох хуулийг батлахад ЭМЯ-нд дэмжлэг үзүүлж, эмнэлгүүдийг биеэ дааж, үр ашигтай ажилладаг болгох зорилгоор эмнэлгийн засаглалыг сайжруулахад анхаарсан.

ЭМСХХ-5 төслийн хүрээнд Монгол улсын эмнэлгээр үйлчлүүлэгч өвчтөнүүд, тэнд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудын аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор цусны аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент болон эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Эдгээр төслүүдийн хүрээнд, эрүүл мэндийн салбарын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй, далайцтай олон ажлууд хийгдэж, үр дүнд хүрсэн.

Өнөөг хүртэл АХБ-наас Монгол Улсын эрүүл мэндийн салбарт нийт 254.99 сая ам.долларын тусламж үзүүлсний дотор 197.04 сая ам.долларын зээлийн 8 төсөл, 42.98 сая ам.долларын буцалтгүй тусламжийн 10 төсөл, 14.97 сая ам.долларын техник туслалцааны 15 төсөл багтаж байна. ⁴

Дээр дурьдсан төслүүд амжилттай хэрэгжин дуусч, ЭМСХХ-6 төсөл буюу “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” хэрэгжилтийн үе шатандаа явж байна.

ЭМСХХ-4 ТӨСӨЛ ХЭРЭГЖИХИЙН ӨМНӨХ УЛААНБААТАР ХОТЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч хотын 9 дүүрэгт нийт хүн амын тэн хагас буюу 1,5 сая хүн оршин суудаг.

Улаанбаатар хот олон эмнэлгүүдтэй ч тэдгээр нь хүчин чадал багатай, үзүүлдэг тусламж үйлчилгээний төрөл нь хязгаарлагдмал. Хэдийгээр манай улс эмнэлэг болон орны тоогоороо дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад чамгүй дээгүүр ордог ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнгийн хувьд төдийлөн сайн биш, хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангаж чаддаггүй. Жишээлбэл, дүүргийн эмнэлгүүд нь голдуу хүүхэд, дотор, мэдрэл гэсэн гурван л чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг бол дэлхийн ихэнх улс орнууд хүний эрүүл мэндийн түгээмэл хэрэгцээг хангах үндсэн долоон тусламж үйлчилгээнээс гадна 10 төрлийн тусламж үйлчилгээг нэг дор

үзүүлэх тогтолцоог хамгийн үр дүнтэй гэж үздэг. Нэмээд, эмийн хэрэглээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо өндөр хэдий ч зүрх судасны болон хавдрын өвчлөл, нас баралтаар Монгол улс дэлхийд тэргүүлж байгаа нь эмийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанартай үр ашигтай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж чадахгүй байна гэж дүгнэж болно. Тиймээс, эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, тусламж үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх, шинэчлэх, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдэх зорилгоор АХБ эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрүүдийг Монгол улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлдэг.

Хүн амын дунд амьсгал, хоол боловсруулах, зүрх судасны тогтолцооны өвчлөл 1990-ээд оноос хойш нэмэгдэж, нас баралтын 80 гаруй хувийг зүрх, судасны тогтолцооны өвчин, хавдар, осол, гэмтлийн шалтгаан эзэлж байна. Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр нас барсан 3 хүн тутмын нэг нь зүрх, судасны тогтолцооны өвчнөөр, 5 хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас, 6 хүн тутмын нэг нь гэмтэл, хордлого, гадны шалтгааны улмаас нас баржээ. Хүн амын дундах өвчлөл, нас баралтын дийлэнх хувийг харьцангуй сэргийлж болох өвчлөл, нас баралт эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд хүн амын дунд ялангуяа тав хүртэлх насны хүүхэд, өсвөр үе, залуучуудын дунд илүүдэл жин, таргалалт нэмэгдэж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Манай улс 11-17 насны хүүхдийн дундах илүүдэл жин, таргалалтын түвшингээр ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнуудаас 2 дугаар байранд орж байна.

Орчны бохирдол жилээс жилд нэмэгдэж өнөөгийн байдлаар Улаанбаатар хотын хүн амын 59.1 хувь нь гэр хороололд суурьшиж, нийслэлийн нийт өрхийн дийлэнх хувь нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдоогүй, автомашины тоо жил тутам өсч байгаа зэрэг нь агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна. Мөн Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын хэт нягтрал, суурьшлаас хамааран хөрс, газрын гүний усны бохирдол өндөр, ундны усыг зориулалтын бус саванд хадгалж байгаа зэрэг нь усны чанар, аюулгүй байдлыг алдагдуулж улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн байдал нь хүн амын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэхгүй байна. Эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээний талаар 2013 онд хийсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар үйлчлүүлэгчдийн 62.4 хувь нь дундаас доош үнэлгээ өгсөн байна.

ДЭМБ-аас 2010 онд хийсэн судалгаагаар эрүүл мэндийн зардалд иргэний төлөх шууд төлбөрийн

эзлэх хэмжээ 41 хувь, 2011 онд Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар 39,7 хувь байгаа нь Ази, Номхон далайн бүсийн бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа төдийгүй ДЭМБ-аас зөвлөмж болгож байгаа хэмжээнээс даруй 16 хувиар их байна.

2015 оны байдлаар эрүүл мэндийн салбарт зарцуулах улсын нэгдсэн төсвийн зардал 9.2 хувь, ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардал 2.4 хувь байна. Гэтэл ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн төвөөс гаргасан “Эрүүл мэндийн санхүүжилтийн стратеги”-д улсын нэгдсэн төсвийн 10-12 хувь буюу ДНБ-ний 5.6 хувийг эрүүл мэндийн салбарт хуваарилан зарцуулахыг гишүүн орнууддаа зөвлөсөн.

Мэдээллийн технологийн үсрэнгүй дэвшлийн өнөө үед өндөр хөгжилтэй орны оношилгоо, эмчилгээний түвшинд хүрэхүйц хэмжээнд эх орондоо эмчлүүлэх иргэдийн хүсэлт өсөн нэмэгдэж байна. Мөн оношилгоо, эмчилгээнд нэвтэрч байгаа шинэ дэвшилтэт технологийг дагасан шинэ эрэлт, хэрэгцээ бий болж байна. Ийнхүү өсөн нэмэгдэж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг одоогийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх хангаж чадахгүй байгаа тул хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар баримтлах бодлогыг шинээр төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Олон улсын жишгээр анхан шатны ихэнх тусламж үйлчилгээг өрхийн болон сумын эрүүл мэндийн төвөөс, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгээс үндсэн мэргэжлийн буюу мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, дотор, хүүхдийн гэх мэт тусламж үйлчилгээг, хүн амын багахан хэсэг нь төв эмнэлгээс төрөлжсөн, тусгай мэргэжлийн тусламж

үйлчилгээг авдаг тогтолцоотой бөгөөд энэ нь тусламж үйлчилгээг оновчтой үзүүлэх, орны ачааллыг бууруулах, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтын хуваарилалт болон эмч, мэргэжилтэн, судлаачид ба эмнэлгүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн олон талын үр ашигтай тогтолцоо юм.

ОЛОН УЛСЫН ЖИШИГ ТОГТОЛЦОО

Өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв

Анхан шатны тусламж үйлчилгээ

Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг

Үндсэн мэргэжлийн: эмэгтэйчүүд, хүүхэд, мэс засал, эх барих, дотор

Эрдэм шинжилгээний төв эмнэлэг

Төрөлжсөн, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР

4, 4+ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Эрүүл мэндийн салбарын үр өгөөжийг дээшлүүлэн, эмнэлгийн засаглал, бие даасан байдал болон эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, улсийн хэмжээнд эмийн аюулгүй байдлыг сайжруулна. Тус төсөл нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарт АХБ-наас хэрэгжүүлсэн салбарыг хөгжүүлэх өмнөх төслүүдийн үргэлжлэл болно.

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН 7 ҮНДЭСЛЭЛ

01 Төслийн хүрээнд Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог сайжруулж, улсийн хэмжээнд эмийн аюулгүй байдлыг бэхжүүлнэ. ЭМСХХ 4 төсөл нь Үндэсний хөгжлийн стратеги болон Засгийн газрын Эрүүл мэндийн салбарын

мастер төлөвлөгөө (2006-2015)-тэй уялдан, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт зэрэг салбарын шинэчлэлийг үргэлжлүүлэн дэмжинэ. АХБ-ны Хараат бус үнэлгээний газар (ХБҮГ)-ын зөвлөмжүүдэд салбарын хоёр болон гуравдугаар шатлалын, ялангуяа Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээний нүсэр тогтолцоог зөв зохистой болгон эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах бүтцийн өөрчлөлт хэрэгтэй байгааг онцолсон. Энэхүү төсөл нь 2009-2012 оны АХБ-ны Улс орны Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө болон 2010-2015 оны Улс орны түншлэлийн стратегид багтсан. Төсөл нь АХБ-ны 2020 он хүртэлх Стратеги болон уг стратегийн бүрэлдэхүүн хэсэг болох Эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдан, салбарын засаглалын асуудлуудыг шийдвэрлэх, эрүүл мэндийн салбарын нөөцийн хуваарилалтыг илүү үр өгөөжтэй болгох зэрэгт анхаарсан.

02 АХБ бол эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлж байгаа хамгийн том гадаад

санхүүжүүлэгч түнш бөгөөд Монгол улсын эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлдэг. АХБ зээл тусламжийн үр өгөөжийг сайжруулах үүднээс “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд тусгайлан дэмжлэг үзүүлдэг. Тус төслийн хүрээнд ДЭМБ-аас мөнгөн бус дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

03 ЭМЯ-ны төсвийн дийлэнх хэсэг эмнэлгийн тусламж үйлчилгээнд зарцуулагддаг ба хүчин чадлын илүүдэл, хангалтгүй бүтээмж, хэт тархай бутархай байдал, үйлчилгээний чанар сул зэрэг нийтлэг хүндрэл бэрхшээл эмнэлгүүдэд тулгарч байна. Өнөөдөр Улаанбаатар хотод 2 болон 3 дугаар шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 50 гаруй эмнэлэг байна. ЭМЯ-ны харьяа 2 ба 3 дугаар шатлалын 6 мэргэшсэн эмнэлэгт хавдар, гэмтэл согог, сэтгэцийн эмгэг, арьсны өвчин, хүүхэд, төрөх болон нярайн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. Дүүргийн эмнэлгүүд Улаанбаатар хотын захиргаанд харьяалагддаг ба ихэвчлэн дотор болон мэдрэлийн чиглэлээр цөөн тооны үйлчилгээ үзүүлдэг. Өрхийн болон дүүргийн эмнэлгүүдийн үйлчилгээний чанар дутмаг байдгаас өвчтөнүүд 3 дугаар шатлалын

эмнэлгүүдэд ханддаг бөгөөд энэ нь анхан шатны үйлчилгээ авах зардлыг өсгөдөг байна.

04 Улаанбаатар хотод төвлөрсөн хувийн эмнэлэг, клиник, лаборатори, эмийн сан зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын тоо хурдацтай нэмэгдэж байгаа ч бодлого зохицуулалт сул, улс ба хувийн эмнэлгүүдийн барилга, тоног төхөөрөмж ерөнхийдөө хуучирсан, нарийн мэргэжлийн эмч нарын сургалт олон улсын шилдэг туршлагад нийцдэггүйн дээр эмнэлгүүдийн менежментийн түвшин сул байна. Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв сайн байгаа тул эмнэлгийн салбар дах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, түүнийг зөв ашиглах, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах нь чухал сорилт болоод байна.

05 Улаанбаатар хотын эмнэлгийн салбарыг бүхэлд нь шинэчлэхэд ойролцоогоор 450 сая ам.доллар шаардлагатай гэсэн тооцоо бий. Ирээдүйн хөрөнгө оруулалтыг үр дүнтэйгээр ашиглаж, хязгаарлагдмал төсвийг зөв стратегиар зарцуулах нь салбарын хувьд чухал асуудал. Улаанбаатар хотын эмнэлгүүдийг шинэчлэх нэгдмэл алсын хараа, эмнэлгийн бодлого,

хууль эрх зүй, зохицуулалт, тогтолцооны шинэчлэл, чадавхын хөгжил, санхүүгийн эх үүсвэрийг бүхэлд нь багтаасан эмнэлгийн шинэчлэлийн төлөвлөгөө дутагдаж байсан. Шийдвэр гаргагчдын хувьд эмнэлгийн менежмент, тусламж үйлчилгээний тогтолцоог сайжруулах, тэр дундаа дүүргийн эмнэлгийн үйлчилгээг олон төрөлтэй болгох тал дээр мэдлэг, ойлголт хангалтгүй байдаг.

06 Монгол Улсад эмийн хууль бус импорт, стандарт бус болон хуурамч эм зах зээл дээр худалдагдах зэрэг асуудал газар авсан. Эмийн зохицуулалтын чиг үүрэг олон байгууллагад хуваагдсан, дотоодын эм үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн зохистой дадлын нийцлийг хангадаггүй. Олон нийтэд мэдээлэл хүргэх, эмийн талаар таниулан сурталчлах, зах зээлийн судалгаа хийх ажиллагаа муу хөгжсөн. Зах зээлд аюулгүй байдал нь хангагдаагүй эм зарагдахаас үүдэх нийгэм, эдийн засгийн өртөг өндөр, энэ талаарх шийдвэр гаргагчдын ойлголт дутмаг, дан ганц зах зээлийн механизмаар шийдвэрлэх боломжгүй тул эмийн аюулгүй байдлыг хангахад засгийн газрын оролцоо зайлшгүй шаардлагатай. Монгол Улсын эмийн аюулгүй байдлын дотоодын чадвар дутмаг тул хөрөнгө оруулалт, техникийн

туслалцаа шаардлагатай байна.

07 Эмнэлгийн үйлчилгээг шинэчлэх шаардлага байгааг 10 гаруй жилийн өмнө тодорхойлсон ч ахиц дэвшил төдийлөн гараагүй ба Засгийн газрын 2006-2015 оны Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөнд тодорхой тусгасан. Салбарын шинэчлэл дорвитойгоор хэрэгжих боломж өдгөө урьд өмнөөс илүү байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, эрүүл мэндийн тогтолцоонд төр-хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт, менежментийн нөөцийг ашиглах боломж нээгдсэн; хоёрдугаарт, олон нийт шинэчлэлийг хүчтэй шаардаж байна; эцэст нь, тогтолцоог сайжруулах зайлшгүй шаардлагатай болсныг улс төрийн дээд түвшинд ухаарч эхэлсэн. Энэхүү төслийн хүрээнд, салбарын ирээдүйн шинэчлэлийг төлөвлөх, хөрөнгө оруулалтын нийгэм-эдийн засгийн үр өгөөж зохистой түвшинд байхыг баталгаажуулах чиглэлээр Монгол Улсад дэмжлэг үзүүлнэ. Үүний тулд, төрийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах, эмнэлгийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон нийтийг хуурамч, стандарт бус эм, бодисоос хамгаалах, эмнэлгийн гүйцэтгэл болон эмийн аюулгүй байдлын талаарх мэдээллийн олон нийтэд нээлттэй байдлыг хангах замаар

салбарын засаглал, удирдлагыг сайжруулна. Үүний зэрэгцээ, эмнэлгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх нь засгийн газрын хувьд бүх нийтийн сайн сайхны төлөө төр-хувийн хэвшлийн түншлэлийг өрнүүлэх боломж олгоно. Төслийн зүгээс эмнэлгийн үйлчилгээ, эмийн аюулгүй байдлыг сайжруулах тогтолцооны шинэчлэлд эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулахад анхаарах замаар тэдэнд бодитой үр өгөөж өгөхөөр төлөвлөн ажиллажээ.

Монгол улс анх удаагаа 10 жилийн хугацаатай “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө”-г

2005 онд боловсруулж, Засгийн газар баталсан бөгөөд уг бодлогын баримт бичиг эрүүл мэндийн салбарыг шинэчилэн, сайжруулах арга хэмжээнүүдийг тусгасан байдаг. ЭМСХХ-4, 4+ төслийн үйл ажиллагаа нь энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн утгаар нь дэмжсэн юм.

Төсөл нэгд, Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх, хоёрт, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, гуравт, эмийн аюулгүй байдлыг сайжруулах гэсэн үндсэн 3 бүрэлдэхүүний хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ХӨТӨЛБӨР 4, 4+

БҮРЭЛДЭХҮҮН 1:

УЛААНБААТАР ХОТЫН
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

Улаанбаатар хотын эмнэлгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Эмнэлгийн хөрөнгийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх

Эмнэлгийн засаглалын бие даасан тогтолцоог бэхжүүлэх

Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг барих

БҮРЭЛДЭХҮҮН 2:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ

Төгсөлтийн дараах резидентийн сургалтын хөтөлбөрийг шинэчилэх

Төгсөлтийн дараах резидентийн сургалтын үр дүнг сайжруулах

Эмнэлгийн менежментийн модульг боловсруулах сургалт зохион байгуулах

Төгсөлтийн дараах сувилахуйн сургалтын хөтөлбөрийг шинэчилэх, төрөлжүүлэн бэлтгэх

Туслах сувилагчийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох

Туслах сувилагч бэлтгэх

БҮРЭЛДЭХҮҮН 3:

ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ

Эмийн зохицуулалтын албыг байгуулах

Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах

Эмийн хяналтын лабораторийг шинэчилэн сайжруулах

Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартыг шинэчилэн сайжруулах

Эмийн зах зээлийн дараах тандалт, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх тогтолцоог сайжруулах

Эмийн аюулгүй байдлын засаглалыг бэхжүүлэх

ЭМСХХ-4, 4+ төслийн бүрэлдэхүүн хэсгүүд
тэдгээрийн хүрээнд хийсэн ажлууд

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

АХБ-ны санхүүжилт нь техникийн туслалцаа, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл болон арилжааны зээл гэх мэт төрлүүдтэй. Ямар төрлийн санхүүжилт байх нь тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдал, зээлжих зэрэглэл, төслийн нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, зорилго, зорилтоос хамаардаг.


Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4, 4+

төслийн санхүүжилтийн нийт дүн нь 58,99 сая ам.доллар бөгөөд АХБ-ны буцалтгүй тусламж 14 сая ам.доллар, хөнгөлттэй зээл 38.67 сая ам доллар, Монгол улсын засгийн газрын оролцоо 5.86 сая ам.доллар болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 450,000 ам.долларын мөнгөн бус санхүүжилт олгохоор батлагдсан.

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ (БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРЭЭР)



ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ГЭРЭЭ

ЭМСХХ-4, 4+ төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ, барилга байгууламжийг барих, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр нийт 60 гаруй гэрээ байгуулагдсан. СХДНЭ нь жишиг байхаар төлөвлөгдсөн тул байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, төлөвлөлт, барилга байгууламж, эмнэлгийн хоёр дах орц гарц, зам, гүүр, зогсоол зэргийг цогцоор нь шийдэх, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, хуучин эмнэлгийн барилга байгууламжийг нураахгүйгээр ашиглах болсон зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой нийт гэрээний тал хувь нь буюу 30 гаруй гэрээг байгуулсан.

Төслийн хамгийн том гэрээт байгууллага нь дэлхийн олон улс оронд эмнэлгийн барилга барьсан 39 жилийн түүхтэй, мэргэжлийн өндөр туршлага, чадвартай Австри Улсын “Вамед Инженеринг” компани бөгөөд туслан гүйцэтгэгчээр Монгол улсын “Магнус Сентурион” компани ажилласан юм.

Мөн жишиг нэгдсэн эмнэлэгт суурилагдсан эмнэлгийн болон эмнэлгийн бус, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулахад 10 гаруй ханган нийлүүлэгч, гүйцэтгэгчидтэй хамтран ажилласан. Төслийн хүрээнд нийт 38 дотоод болон гадаадын зөвлөх үйлчилгээ авчээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ХӨТӨЛБӨР 4 & 4+ ГЭРЭЭНИЙ ТӨРЛҮҮД



ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



БАРИЛГА



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1:

УЛААНБААТАР ХОТЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ХӨТӨЛБӨР 4, 4+



УЛААНБААТАР ХОТЫН ЭМНЭЛГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

ЭМСХХ 4, 4 + төслийн хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог тодорхойлсон “Монгол улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль” (2016)-ийн үзэл баримтлалыг боловсруулах, улмаар холбогдох хууль тогтоомжинд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж, дүрэм, журмуудыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн юм.

ЭМЯ, холбогдох оролцогч талуудыг оролцуулсан техникийн ажлын хэсгүүд байгуулагдан, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн

бодлого 2014-2023” (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 55 тоот тушаал) болон энэхүү бодлогыг 2015-2019 хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө (Эрүүл мэндийн сайдын 2015 оны 181 тоот тушаал)-г боловсруулан батлуулж хэрэгжүүлсэн. Үргэлжлүүлэн дээрх бодлогын баримт бичгүүдийн үзэл санааг 2017 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого (2017-2026)”-д тусган хэрэгжүүлж байгаа билээ. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын дунд хугацааны

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Өмнө нь (2000-2015)

АНХАН
ШАТЛАЛ:

Өрх, сумын
эмнэлэг

ХОЁРДАГЧ
ШАТЛАЛ:

Аймаг, дүүргийн
нэгдсэн эмнэлэг

ГУРАВДАГЧ
ШАТЛАЛ:

Төв эмнэлэг

Одоо (2016-2021)

Өрх, сум,
тосгоны
эрүүл
мэндийн төв

Аймаг,
дүүргийн
нэгдсэн
эмнэлэг

Төв, төрөлжсөн,
тусгай
мэргэжлийн
лавлагаа, тусламж
үйлчилгээний
эмнэлэг

“Мастер төлөвлөгөө 2020-2027” бодлогын баримт бичгээс эхлүүлээд салбарын суурь хууль болох “Эрүүл мэндийн тухай хууль” (2012) -ийн нэмэлт өөрчлөлтөд хувь нэмэр оруулсан.

Лавлагаа шатлалын нэгдсэн эмнэлгийн бүтэц, тусламж үйлчилгээний стандартууд шинэчлэгдэн боловсруулагдаж, батлагдан хэрэгжиж байна. Дээр дурьдсан эрх зүйн орчин сайжирч, зохицуулалт бий болсоноор төслийн үр дүнд, Эрүүл мэндийн хуулинд заасанчлан “хүн амд долоогоос доошгүй чиглэл (дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт)-ээр лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх” өндөр хүчин чадалтай, үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй, яаралтай болон эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий Улаанбаатар хотын дүүргийн эмнэлгүүдэд жишиг болохуйц СХДНЭ-ийг барьж байгуулсан билээ.

Дүүргийн эмнэлгүүд зарим төрөлжсөн болон тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломжтой болсноор төрөлжсөн, тусгай мэргэжлийн төвүүд, тухайлбал, ХӨСҮТ, ХСҮТ, ГССҮТ, ЭХЭМҮТ болон Улсын 1, 2, 3 дугаар төв эмнэлгүүдийн ачаалал буурах юм.

Жишиг дүүргийн эмнэлгийн ерөнхий мэс засал, гэмтэл, эх барих эмэгтэйчүүд гэх мэт тусламж үйлчилгээг үзүүлэх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүний нөөцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, сайжруулах замаар 3 дах шатлалын эмнэлгүүд олгой, цөсний хагалгаа гэх мэт үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээнд ихэнх нөөц, хүчин чадал, цаг хугацаагаа зарцуулахааргүй болж, улмаар шатлалынхаа дагуу төрөлжсөн, тусгай мэргэжил шаардах эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээ, эмнэлзүйн туршилт хийх, шинэ арга барил, техник технологийг судлах, турших, нэвтрүүлэх, хүний нөөцөө чадавхижуулах, зүрх, тархи, мэдрэл гэх мэт нарийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, туршлага шаардсан мэс заслуудыг хийж, энэ бүгдийн үр дүнд эмч, эмнэлгийн ажилтнууд, эмнэлэг, эрүүл мэндийн салбар хөгжих боломж улам тэлэх болно.

Эмнэлгийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд хийсэн төслийн бас нэг шинэлэг ажил бол эмнэлгийн гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлэх тогтолцооны талаарх олон улсын жишиг болох сайн туршлагыг судлан турших, улмаар зөвлөмж боловсруулан боломжит хувилбарыг практикт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх явдал байсан юм. Учир нь, эмнэлгийн гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлсэнээр эмнэлгүүдийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг сайжруулах,

үйлчлүүлэгчдэд сонголт хийх боломжийг олгодог.

Төслийн хүрээнд эмнэлгийн гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй мэдээлэх тогтолцооны концепц, шалгуур, хэрэгжүүлэх төлөвлөгөө, гарын авлагыг боловсруулан, төлөөлөл болгон улсын төв эмнэлэг болон аймаг дүүргийн 3 эмнэлэгт туршсан. Энэхүү шинэлэг ажлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын тушаалаар (2021 оны 1 дүгээр сарын А/06 тоот) байгуулагдсан ажлын хэсэг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Ийнхүү ЭМСХХ-4 төсөл эмнэлгүүдийг тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлаа хангах, ил тод, хариуцлагатай, үр ашигтай ажиллаж, улам хүрээгээ тэлэн хөгжих боломжийг бий болгохын төлөө дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Эдгээр санаачлан эхлүүлсэн, одоо амжилттай хэрэгжиж байгаа олон ажлуудыг эрүүл мэндийн байгууллагууд цаашид улам төгөлдөржүүлж нутагшуулан, үргэлжлэн тогтвортой хэрэгжүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

ЭМНЭЛГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМТЭЙ БОЛОХ

ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМ БУЮУ CAPITAL PLANNING SYSTEM

Монгол улсын эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламжийг бэхжүүлэх, хөрөнгийн төлөвлөлтийн тогтолцоог бий болгоход шаардлагатай програм хангамжийг боловсруулах зорилгоор тоног төхөөрөмжийн төлөвлөлтөд хэрэглэгдэх бүртгэлийн системийг хийсэн юм. Энэ ажил Монгол улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх бодлоготой нийцсэний дээр эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлын нэг болох хүн амд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд анагаахын шинжлэх ухааны шинэ ололтууд, оношилгоо эмчилгээний шинэ техник, технологийг цаг алдалгүй нэвтрүүлэн хүн амд үзүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр өгөөжийг улам сайжруулж, нөөцийг үр ашигтай хуваарилах ач тустай ажил болсон билээ.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн мэдээллийн сан байдаггүйгээс дараах асуудлуудтай тулгардаг байлаа. Үүнд:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, шинэ дэвшилтэт техник технологийн хэрэгцээг тодорхойлон шинэчилэх асуудлыг үр ашигтайгаар шийдэж чаддаггүй.
- Улмаар, техник, технологийн оновчтой сонголтыг хийж чаддаггүй.
- Эрүүл мэндийн байгууллагын хувьд төсөв, дэд бүтцийн шинэчлэл, засвар үйлчилгээний зардал, холбогдох эрсдэлийг урьдчилан тооцох боломж байдаггүй.
- Хандив, тусламж болон бусад жижиг төсөл хөтөлбөрөөс эмнэлэгт нийлүүлэгдэж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид тавих нэгдсэн хяналт байдаггүй.



Б. БАТЦООЖ


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, судалгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Үүнээс болж, худалдан авалтын давхардал үүсэж үр ашиггүй худалдан авалт хийгдэх нь элбэг байв. Тиймээс, салбарын хэмжээний эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн мэдээллийн санг хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох, нэгдсэн бодлого төлөвлөлтөөр хангах, хяналт тавих ажиллагаанд хэрэглэхээр зорьж бүтээсэн юм. Ингэснээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн шаардлагатай нөөцийг зөв тодорхойлох замаар салбарын хэмжээнд эмнэлгийн тусламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоог бий болгоно. Түүнчлэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлогыг сайжруулж, шинэ хөрөнгө оруулалтыг зохистой болгон үргүй зардал гарахаас сэргийлэх давуу талтай.

2015 оноос эхэлсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн програм нь өмнө нь хийгдэж байгаагүй шинэ ажил бөгөөд урьд нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийг санхүүгийн програм болон цаасан бүртгэлээр хийж, тайлан тооцоо гаргадаг байв. Энэ програмыг эмнэлгийн тоног төхөөрөмжийн үндсэн мэдээлэл, шалгалт тохируулга, засвар үйлчилгээ, дэвшилтэт технологийг үнэлж хяналт, төлөвлөлт хийдэг нэгдсэн мэдээллийн сан болгон хөгжүүлсэн. Уг програмыг нэвтрүүлснээр эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн талаарх мэдээ, мэдээллийг эмнэлэг болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, төлөвлөгч болон эцсийн хэрэглэгч байгууллагууд хоорондоо түргэн шуурхай солилцох боломж бүрдсэн юм.

Програм хангамжийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, ашиглалтын үр дүн, чанарыг сайжруулах зорилгоор “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн системийн програмын гарын авлага”-ыг боловсруулж, хэвлэн эрүүл мэндийн байгууллагуудад түгээсэн.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн програмыг хөгжүүлэхэд олон улсын нэр томъёоны дагуу бүртгэл хийх



шаардлагатай байсан. Олон улсад Anesthesia Units буюу унтуулгын аппарат гэж нэрлэж хэвшсэн байхад Монгол улсад унтуулгын аппарат, наркозын аппарат, мэдээгүйжүүлэх аппарат, загвар гэх мэт маш олон янзаар нэрлэдэг нь салбарын хэмжээний мэдээлэл гарган судалгаа боловсруулах, хөрөнгийн төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байжээ.

Тиймээс, олон улсад хэрэглэгдэж буй нэр

томъёоны системүүдийг судалж, дэлхийн 100 гаруй оронд албан ёсоор хүлээн зөвшөөрч, тоног төхөөрөмжийн бүртгэл, ангилал, үйл ажиллагааг зохицуулахад хэрэглэж буй "Emergency Care Research Institute (ECRI)"-ээс эрхлэн гаргадаг эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартчилагдсан "Universal Medical Device Nomenclature System (UMDNS)" нэр томъёо ба компьютерын кодын системийг энэхүү системд

ADB ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМ

ЭМНЭЛГИЙН ТӨХӨӨРӨМЖ

Эмнэлгийн тоног төхөөрөмж

	Ерөнхий нэр	Нэр төрөл	UMDNS код	Бүтээгдэхүүн нэр *	Өртөг *	Шилжиж ирсэн	Актлагдсан	Дэвшилтэт технологи	Хөрөнгийн код *	Байгуул
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Амьсгалын аппарат(044210145112)	Хяналтын монитор	10-145	Амьсгалын аппарат	4,029,399	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	044210145112	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Амьсгалын аппарат(009110145108)	Амьсгалын аппарат	10-145	Амьсгалын аппарат		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	009110145108	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Зурхний хөдөлгөөн бичүүр(004710266101)		10-266	Зурхний хөдөлгөөн бичүүр	250,000	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	004710266101	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем(001410396101)	өвчтөний хяналтын монитор /ургийн бичлэгтэй/	10-396	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем	2,479,000	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	001410396101	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем(005810396101)	Хяналтын монитор	10-396	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем	6,230,700	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	005810396101	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	хяналтын монитор (3308)	Хяналтын монитор	10-396	хяналтын монитор	1,747,500	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	3308	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем(005610396101)	Монитор	10-396	Өвчтөний биеийн байдлыг электрон хэрэгслээр хянах систем	3,115,325	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	005610396101	
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Компьютер(027410977101)	Монитор	10-977	Компьютер	718,000	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		

Solve PC issues: 2 important messages

авч ашигласан юм.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн А/493 дугаар тушаалаар “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах” журмаар уг програмын үйл ажиллагаа зохицуулагддаг. АХБ-ны ЭМСХХ-4 төслийн дэмжлэгтэйгээр програмын гарын авлага 300 ширхэг, нэр томьёоны толь бичгийг 500 ширхэг хэвлүүлэн програм хэрэглэгчдэд

өгсөн. Програмын ашиглалтын сургалтыг 2017-2020 онуудад давхардсан тоогоор 157 байгууллагын 370 гаруй ажилтанд цахим болон танхимаар зохион байгуулсан. 2021 оны 05 сарын байдлаар уг програмд улсын болон хувийн хэвшлийн 392 эрүүл мэндийн байгууллагын 993 хэрэглэгч ашиглан, 23311 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл бүртгэгдсэн байна.

ЭМНЭЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ

СХДНЭ-ИЙН БАГИЙН ЧАДАВХИЖУУЛАЛТ

Монгол улсад олон улсын эмнэлгийн JCI стандартуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж, нэр хүнд бүхий магадлан итгэмжлэлийг авсан анхны эмнэлэг бол Интермед юм. JCI магадлан итгэмжлэлийн хүрээнд орчин үед эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх тэргүүн туршлагыг төлөвшүүлэх 300 гаруй стандарт, 1100 гаруй хэмжих үзүүлэлтүүд байдаг бөгөөд энэ бүгдийг Интермед эмнэлэг гардан нутагшуулсан туршлагад нь үндэслэн СХДНЭ-ийн багийг чадавхижуулах зөвлөх үйлчилгээг үзүүлэх байгууллагаар сонгосон юм.

JCI магадлан итгэмжлэлээ 2016 онд авсан Интермед эмнэлгийн баг СХДЖНЭ-т удирдлага, менежмент, засаглалын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хүний нөөц, сувилахуйн тусламж үйлчилгээний туршлагаасаа хуваалцаж, зөвлөж, ажилласан.

Зөвлөх баг СХДНЭ-т орчин үеийн эмнэлгийн засаглал, бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, чанар, аюулгүй байдал болон сувилахуйн тусламжийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны холбогдох стандарт, дүрэм журмыг боловсруулан, эмнэлгийн удирдлагын

баг болон ажилтнуудад эдгээр дүрэм журмуудыг хэрэгжүүлэх арга зүйд сургасан юм. Ингэхдээ олон улсын JCI магадлан итгэмжлэлийн стандартуудад үндэслэн, манай улсын нөхцөл байдалд тохирсон суурь систем, үйл ажиллагаануудыг сонгож, Интермед эмнэлэгт ашиглагдаж буй стандарт, дүрэм журмуудыг СХДЖНЭ-ийн нөхцөл байдалд тохируулан өөрчилж боловсруулсан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэг нь зочид буудлын болон эмнэлзүйн тусламж үйлчилгээний хослол байдаг. Тиймээс, олон функц бүхий алба нэгжүүдийн үйл ажиллагааг нягт уялдуулж, үр дүнтэй хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, хариуцлагын гол механизм нь эмнэлгийн зөвлөл хороодыг байгуулах явдал байдаг бөгөөд энэ шийдэл СХДНЭ-ийн засаглал, бүтэц зохион байгуулалтын саналд тусгалаа олсон нь сайшаалтай. Түүнчлэн, сувилахуйн тусламж нь эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үзүүлэх болон үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас онцгой ач холбогдол өгч, СХДНЭ-ийн менежментийн түвшинд төлөөллийг нь оруулжээ.



2019 онд JCI магадлан итгэмжлэлийн шалгалтыг дахин амжилттай давж, магадлан итгэмжлэлийн батламжаа хүлээн авсан хамт олон



Интернэйшнл Медикал Сентер компанийн Интермед эмнэлгийн зөвлөх багийн бүрэлдэхүүнд төслийн багийн удирдагчаар ажилласан Жошуа Курциг нь Интермед эмнэлгийн төсөлд гар бие оролцон, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байснаас гадна АНУ, БНХАУ-д шинэ эмнэлгийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байсан туршлагатай мэргэжилтэн юм.

Сувилахуйн олон улсын зөвлөхөөр ажилласан Сохейла Рохани нь Интермед эмнэлгийн төслийн сувилахуйн зөвлөх, анхны Сувилахуй эрхэлсэн захирлаар ажиллаж Монголын сувилахуйн салбарыг олон улсын түвшинд ойртож очиход гар бие оролцож явсан туршлагатай сувилахуйн менежер билээ.





Зөвлөх багийн гишүүд СХДНЭ-н барилгын тайлбай дээр

Зөвлөх үйлчилгээг үзүүлэх хугацаанд дэлхий даяар Ковид-19 цар тахал дэгдэж, төслийн хэрэгжилтийн явцад сөргөөр нөлөөлсөн ч Интермедийн зөвлөх баг АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгж, Төслийн удирдлагын баг болон Эмнэлгийн удирдлагын багуудтай нягт хамтран ажиллаж, үйл ажиллагааг зохицуулан ажилласан. Мөн СХДНЭ-ийн удирдлагын баг,

тасаг нэгжийн ажилтнууд шаардлагатай үедээ, цаг заваа тохируулан Интермед эмнэлэгт ирж ажиллан, ажлын байран дээр ажиглалт хийх, суралцах, сургалтанд хамрагдах, мэдэхгүй зүйлээ мэдэж авах, хэрэгтэй үйл ажиллагаатайгаа танилцах, дагалдах, туршлага судлах зэрэг боломжтой байсан нь тэдэнд үйл ажиллагаандаа олон улсын стандарт,

**Т.БОЛОРМАА**

Интермед эмнэлгийн Ерөнхийлөгч

“Манай Интермед эмнэлгийн Зөвлөх баг эмнэлгийн орчин үеийн удирдлага зохион байгуулалт, тусламж үйлчилгээний олон улсын чанар, аюулгүй байдлын стандартуудыг

нутагшуулсан туршлагаа бусадтай хуваалцах боломж гарсан нь нэр хүндийн хэрэг байлаа. Ялангуяа энэ салбарын мэргэжилтнүүдийн хувьд энэ төслийн хүрээнд дүүргийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлэх олон улсын түвшний дэд бүтэцтэй барилга байгууламж бий болж, технологийн шийдлүүд бүрдэж, эмнэлгийн менежмент болон тусламж үйлчилгээ явуулах үйл явцыг олон улсын жишигт нийцүүлэхийн төлөө чамгүй олон ажлууд хийгдэж байгаад бид их ач холбогдол өгч, ажилласан. Хамтын ажиллагааны хүрээнд тус эмнэлэгт нутагшуулахаар зорьсон стандарт, дүрэм журмуудын хэрэгжүүлэлт, эмнэлгийн үйл ажиллагаа төлөвшитлөө даруй 2-3 жилийн тогтвортой хичээл зүтгэл шаардлагтайг бид өөрсдийн туршлагаасаа мэдэх юм. Иймд Зөвлөх багийн зөвлөх үйлчилгээ дууссан хэдий ч Интермед эмнэлгийн зүгээс СХДЖНЭ-ийн ажилтнуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн өөрийн эмнэлэг дээр холбогдох тасаг нэгжүүдийн үйл ажиллагаа, үйл явцтай танилцах, дагалдах, суралцах боломжоор ханган, туршлага хуваалцан хамтран ажилласаар байна.”.

дүрэм журмыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд тус дөхөм болохын зэрэгцээ олон улсын туршлага судлахаар гадагшаа явах шаардлага гараагүй нь цаг болон зардал хэмнэх ач холбогдолтой байв.

Зөвлөх баг СХДНЭ-т нэвтрүүлэх стандарт, дүрэм журмуудыг нөхцөл байдалтай уялдуулан тохируулсаны дараа нэвтрүүлэх, хэмжих үзүүлэлтийг тодорхой болгох, тодорхой хугацааны дараа төслийн үр дүнг хянах, үр дүнг бататгах ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлэхийг зөвөлсөн. Энэхүү суурь стандарт дүрэм журмуудыг мөрдөж ажиллаж сурснаар цаашид тасралгүй хөгжих нөхцөл бүрдэх юм.

Эмнэлгийн барилга байгууламж, технологийн шийдлүүд нь эрүүл мэндийн чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч хамгийн чухал нөхцөлдүүлэгч нь эмнэлгийн багийн хамтын ажиллагаа, мэргэжлийн багийн чадавх, түүнийгээ тасралтгүй сайжруулах болон тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эмнэлгийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэдэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх явдал юм.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЖУУЛАЛТ

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн менежмент нь Эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэгч 6 үндсэн бүрэлдэхүүний хамгийн чухал нэг хэсэг нь юм. Эмнэлгийн хүний нөөцийн тогтолцоог зөв бүрдүүлснээр үйлчлүүлэгчид чанартай, үр дүнтэй тусламж үйлчилгээг үзүүлэхээс гадна үйлчлүүлэгчийн болон ажиллагсдын сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлдөг. Иймд байгууллагын хамгийн чухал үнэт зүйл бол хүний нөөц байдаг. Хичнээн сайхан барилга байгууламж, тоног төхөөрөмж байгаад ч тэнд ажиллаж буй ажилтнуудын мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, байгууллагын эерэг зөв соёлыг бий болгохгүйгээр хүн амд олон улсын жишигт хүрсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломжгүй юм.

2019 оны 5 дугаар сараас зөвлөх баг үйл ажиллагаагаа эхлүүлэн ЭМЯ, НЭМГ, СХД-ийн хүүхдийн эмнэлгийн удирдлагын баг, хамт олон, АХБ-ны төсөл хэрэгжүүлэх нэгж, СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл зэрэг төслийн хамтрагч талуудтай уулзалтуудыг хийж байлаа.

Эхлээд хүний нөөцийн менежментийн чиглэлээр нөхцөл байдлын үнэлгээг хийсэн. Ингэхдээ Эрүүл мэндийн удирдахуйн ухаан (Management Sciences for Health) олон улсын нэр хүнд бүхий





Д.ЭНХТУЯА

*Интермед эмнэлгийн
Эмнэлгийн мэргэжилтний
албаны дарга*

*Олон улсын зөвлөх
багийн Хүний нөөцийн
үндэсний зөвлөх, төслийн
менежер*

*Анагаах ухааны болон
Олон улсын нийгмийн
эрүүл мэндийн магистр*


“Зөвлөх үйлчилгээний хүрээнд, хүний нөөцийн төлөвлөлтөнд заагдсан дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах ёстой ажлын байрны үнэлгээг хийж, нийт 120 гаруй ажлын байрны тодорхойлолтуудыг боловсруулж, хүний нөөцийн төлөвлөлтийг шат дараатайгаар хэд хэдэн удаа хийсэн юм. Энэ явцад хүний нөөцийн дутагдалтай байдал, Сангийн яам болон ЭМЯ-наас баталж өгсөн хүний нөөцийн батлагдсан төсөвтэй холбоотой хүндрэлтэй нөхцөлүүд тохиолдож байсан. Тэгээд ч дүүргийн нэгдсэн эмнэлгийн стандартад тохирсон хүний нөөцийг төлөвлөх тийм ч амар биш. Ялангуяа Монголд сувилагчийн хүрэлцээ муу байгаа нь бүгдийг ном журмын дагуу хийх боломжийг олгохгүй байв”.

байгууллагаас боловсруулсан Төрийн болон Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн менежментийн үнэлэх үнэлгээний аргыг ашигласан. Уг үнэлгээн дээр үндэслэн хүний нөөцийн чиглэлээр цаашид СХДНЭ-т шууд нутагшуулан хэрэглэж болох дүрэм журмуудыг хамтран боловсруулсан. Түүнчлэн, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулав.

Хэдийгээр цар тахлын үед танхимын сургалтуудыг олноор зохион байгуулах

боломжгүй байсан ч нөхцөл байдалдаа зохицон танхимийн, ажлын байран дээрх, цахим сургалтуудыг тасралтгүй явуулж байлаа. Ялангуяа, Интермед эмнэлэг дээрх ажлын байран дах танилцах сургалтууд их үр дүнтэй болсон. Учир нь олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж гаргасан дүрэм журмын дагуу тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлж байгааг өөрсдийн нүдээр харж, заримд нь оролцон, үйл ажиллагааны урсгалуудтай биечлэн танилцах боломжтой байсан юм.





СУВИЛАХУЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Интермед эмнэлгийн зөвлөх баг 2019 онд СХД-ийн эмнэлэгтэй танилцаж, эмнэлгийн менежментийн багтай уулзаж нөхцөл байдлын дүгнэлт хийн, түүн дээрээ үндэслэн сувилахуйн тал дээр сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж, зөвлөмж өгсөн. Сувилахуйн зөвлөх үйлчилгээний багт өмнө нь Интермед эмнэлэгт 1 жилийн хугацаанд сувилахуйн албаны сувилахуй эрхэлсэн захирлаар ажиллаж байсан Сохейла Рохани хэмээх Америк зөвлөх сувилагч хамтран ажилласан.

Тэрээр СХДНЭ-ийн ахлах сувилагч нарт менежментийн талаар сургалт, дүрэм журам боловсруулах тал дээр зөвлөмж өгсөн юм. Зөвлөх үйлчилгээний хүрээнд, сувилахуйн менежмент болон бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, сувилахуйн албаны хүний нөөцийг сайжруулах, сувилахуйн албаны сургалт хөгжлийг сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах олон улсын 6 зорилтыг СХДНЭ-т нэвтрүүлэх, эмнэлгийн дотоод яаралтай тусламжийн үйлчилгээ, сувилахуйн албаны баримтжуулалт, урсгал зохион байгуулалтыг сайжруулах зэрэг чиглэлүүдээр зөвлөх үйлчилгээг үзүүлсэн.

Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоонд сувилахуйн алба нь эмчилгээ эрхэлсэн



орлогчийн харьяанд үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн байдаг. Интермед эмнэлэг анх удаа сувилахуйн албаа удирдлагын багтаа нэгтгэж, эмчилгээ эрхэлсэн захиралтай нэг түвшинд ажиллуулсан туршлагаа бусадтай хуваалцаж, СХДНЭ-ийн сувилахуйн бие даасан алба байгуулж, эмнэлгийн Сувилахуйн албаны даргыг эмнэлгийн удирдлагын багийн нэг гишүүн болгохыг зөвлөснийг бодит ажил болгохоор ажиллаж байна.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОЛОН УЛСЫН 6 ЗОРИЛТ

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ
ЗӨВ ТАНИХ

ХАРИЛЦАА ХОЛБООГ
САЙЖРУУЛАХ

ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ЭМИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

ЗӨВ МЭС ЗАСАЛ, ЗӨВ
АЖИЛБАР, ЗӨВ
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ХИЙХ


ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

ЯВГАНААС УНАХААС
СЭРГИЙЛЭХ

Сувилахуйн алба сайн менежменттэй байснаар бие даасан тусламж үйлчилгээг чанартай үзүүлж чадна. Тиймээс, ахлах сувилагч нарын сонгон шалгаруулалт, тэдний чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарсан. Харамсалтай нь ковидын нөхцөл байдалтай холбогдуулаад ганцаарчилсан, бие даасан, эмнэлэг дээр туршлага судлах сургалтууд хойшлогдсон ч онлайн сургалтуудыг хийсэн.

Дэлхийн жишигт хүрсэн тусламж үйлчилгээ

үзүүлэхэд хамгийн чухал зүйл бол үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах явдал юм. Олон улсын түвшний тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлэг үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах Олон улсын 6 зорилтыг нэвтрүүлсэн байх ёстой байдаг. Энэ ажлыг гол хэрэгжүүлэгч нь сувилагчид, сувилахуйн албаныхан юм. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах олон улсын дээрх 6 зорилтын хүрээнд Зөвлөх баг нийт 16 журмыг СХДНЭ-т боловсруулж өгсөн.



СХДНЭ-ийн Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

СУВИЛАХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛТ:

Эмнэлгийн бүх сувилагч нарыг шууд удирдах Сувилахуйн албыг Монгол улсад анх удаа бие даалган байгуулан ажиллуулж, эмч сувилагчийн харьцааг 1:2-д хүргэнэ

СУВИЛАХУЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





Б. АМАРМЭНД

*Интермед эмнэлгийн
Сувилахуй эрхэлсэн захирал*

“Сувилахуйн алба өөрийн бие даасан сургалтыг хийдэг байх ёстой. Тиймээс, бид сургалт хариуцсан арга зүйчийн орон тоог бий болгож, Интермед эмнэлгийн туршлагаас судлан шинээр орж байгаа сувилагч нарт 4 хоногийн чиглүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрт эмнэлэгт хэрэгжиж буй дүрэм журам, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах журмууд, сувилахуйн гардан хийх үйлдлүүдийн стандартууд зэргийг зааж сургахаар багтаасан”.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд Интермед эмнэлгийн зөвлөх баг нийт 33 сувилагч, туслах сувилагч болон техникч нарын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, тэдний хийх ажил, байгууллагын дүрэм журам, хэрхэн ажиллах талаар зөвлөмж боловсруулж өгсөн. Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн эм тариа, эмчилгээ хийхээс гадна сувилахуйн үнэлгээг сайн хийж сувилахуйн 5 шатлалын дагуу ажилладаг байх хэрэгтэй. Тиймээс сувилахуйн дараах үнэлгээнүүд болох эрт үеийн анхааруулах, өвдөлтийн, уналтын зэрэг үнэлгээнүүдийг шинээр нэвтрүүлсэн. Эдгээр нь үйлчлүүлэгчийг эрсдэлээс сэргийлж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх, цаашлаад эмчилгээ үйлчилгээ чанарыг илүү сайн байлгахад тустай байдаг билээ.



Б. АЛТАНЦЭЦЭГ

*ЭМСХХ Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн
Төлөвлөлт, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн.*

*Зөвлөх үйлчилгээний худалдан авалт, чанар,
хяналт, гэрээний хяналтыг хариуцан ажилладаг*

*“АХБ-наас бусад улс оронд хэрэгждэг сайн
туршлагуудыг нэвтрүүлж, нутагшуулах
зорилгоор гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээг
авч ажиллуулсаны нэг нь СХДЖНЭ-ийн төслийн
хүрээнд нэвтрүүлсэн эрүүл мэндийн тусламж
үйлчилгээний чанар, хүртээмжийг олон нийтийн
оролцоотой сайжруулах аргачлал байв”.*

ОЛОН НИЙТИЙН ОНООНЫ КАРТЫН АРГААР СХДНЭ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛНА

Төслийн хүрээнд төслийн гэрээт зөвлөх байгууллага “МонКонсалт” ХХК-ийн Олон нийтийг идэвхжүүлэх зөвлөх баг 2015-2019 онд СХДНЭ-ийн тусламж үйлчилгээний чанарт бодитой ахиц дэвшил гаргах зорилгоор тус эмнэлгийн тусламж үйлчилгээний байдалд Олон нийтийн онооны карт (ОНОК)-ын аргыг ашиглан үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн эмнэлгийн тусламж үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан юм.

Энэ ажлын гол стратеги нь үйлчилгээ үзүүлэгч буюу эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, үйлчлүүлэгч буюу олон нийт болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарын дунд харилцан ойлголцол бий болгох, тэд хамтдаа эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлон төлөвлөх, хэрэгжүүлэх, хамтран хяналт шинжилгээ хийх явдал байв.

СХД-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний байдлыг 5 жилийн хугацаанд нийтдээ 5 удаа Олон нийтийн онооны картын аргаар тус дүүргийн хүн амд эрүүл мэндийн тусламж

үйлчилгээ үзүүлж буй бүхий л түвшний байгууллагын үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид, эмнэлгийн удирдах ажилтнууд болон СХД-ийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн, хороодын дарга, нийгмийн ажилтнууд, хэсгийн ахлагч, бэлтгэгдсэн “Хүрч очих ажилтан”-уудаас бүрдсэн нийт 877 хүнийг оролцуулан үнэлжээ.

Иргэд, үйлчлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар, ТББ-уудын хамтарсан уулзалтын үр дүнд, оролцогчид тусламж үйлчилгээний талаар илүү сайн ойлголттой болж дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах зэргээр оролцоо нь нэмэгдсэн. Мөн эрүүл мэндийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас иргэд үйлчлүүлэгчдийн үгийг сонсож, тэдэнтэй ойр ажиллаж, хувь нэмрээ оруулах, хамтарч ажиллах сэдлийг төрүүлж идэвхи, оролцоог улам бүр дэмжих болжээ.

Түүнчлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар олон нийтийн зүгээс санал бодлоо илэрхийлэх, биеэр оролцох боломж олгож, хамтран ажилласнаар, тэргүүлэх чиглэлийг зөв тодорхойлох, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангахад тохиромжтой орчныг бүрдүүлэх, ингэснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид ахиц дэвшил гарч, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.







Г. ЦЭЦЭГДАРЬ

АУ-ны Доктор, ОНИЗБ-ийн ахлагч

Олон нийтийг идэвхжүүлэх зөвлөх
багийн Ахлагч

СХД-ийн хүн амд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээний байдалд ОНОК-аар үнэлгээ хийх үйл ажиллагааг жил бүр тогтмол давтамжтай 5 удаа зохион байгуулснаар СХДНЭ-ийн үйл ажиллагаанд 50 гаруй, Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 70 гаруй өөрчлөлт, ахиц дэвшил гарсан юм.



СХД-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний байдлыг ОНОК-аар үнэлсэн үнэлгээний тайлангууд болон тус эмнэлгээр төсөл хэрэгжихийн өмнө болон хэрэгжсэний дараа үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлангуудыг СХДНЭ ба бусад эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны удирдлагууд, холбогдох ажилтнуудад хүргүүлэн мэдээллээр хангаж, ажилласан.

ТОХИОЛДСОН БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛСАН АРГА ЗАМ

ОНОК-аар үнэлгээ хийх гэдэг нь шинэ ойлголт учраас эхэндээ үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчлүүлэгч/олон нийтийн зүгээс ойлгож хүлээн зөвшөөрөхөд цаг хугацаа ихээр шаардагдаж байсан. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд бид өөрсдийн үйл ажиллагаанд оролцуулж дэмжлэг авах зорилгоор хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарт 6 удаагийн сургалт явуулан нийт 364 хүнийг “Хүрч очих ажилтан”-аар бэлтгэж, тэдэнтэй хамтран иргэд буюу үйлчлүүлэгчдийн дунд бүсчилсэн өдөрлөг зохион байгуулж ОНОК-аар үнэлгээ хийх арга, ач холбогдол, жишиг нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог давуу тал, эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, сурталчилгаа явуулж, сурталчилгааны материал түгээж ажилласнаар иргэд, үйлчлүүлэгчдийн оролцоо, дэмжлэг, идэвх мэдэгдэхүйц нэмэгдэж ирсэн.

Жишээ нь, СХДНЭ барих газар дээр иргэдийн автомашины 10 гаруй гараж байрлаж байсан бөгөөд тэд эхэндээ хувийн өмчөө хамгаалж эсэргүүцэн газрыг чөлөөлөх дургүй байв. Ингээд тэдэнтэй удаа дараа уулзаж, шинээр баригдах жишиг нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл





ажиллагааны онцлогийг танилцуулах өдөрлөг, ОНОК-аар тусламж үйлчилгээнд үнэлгээ хийлгэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг үйл ажиллагаанд урьж оролцуулах, өөрсдөөр нь асуудлыг гаргуулж хэрхэн шийдвэрлэж болох тухай яриулах зэрэг оролцоонд тулгуурласан олон аргуудыг ашигласны үр дүнд барилга барих газрыг чөлөөлж, гаражнуудаа нүүлгэсэн юм. Түүнчлэн иргэд бусдад өөрсдийн хийж чадсан сайн зүйлийнхээ талаар ярьж ухуулга нөлөөллийн ажилд идэвхтэй оролцсон. Ийнхүү үйлчлүүлэгч, олон нийтийн оролцоог ханган идэвхжүүлж ажилласнаар тэд өөрсдийн зүгээс юуг хийж



чадах вэ гэдгийг сайтар ойлгож улмаар шийдвэр гарган, хэрэгжүүлж чаджээ.

Энэхүү амжилт, арга туршлагаа АХБ-наас зохион байгуулдаг хурал, сургалт семинарын үеэр бусад төсөл хөтөлбөрүүдэд танилцуулахын зэрэгцээ

“Олон нийтийн онооны картаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх нь” гарын авлагыг боловсруулан хэвлүүлж бусад байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн хамт олонд илгээн, туршлагаа хуваалцан, түгээн дэлгэрүүлж байна.



СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРГИЙН ЖИШИГ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ БАРИХ

АНХНЫ САНАА



Ж.АЛТАНТУЯА

*АХБ-ны Монгол дах Суурин төлөөлөгчийн газрын
Нийгмийн салбар хариуцсан ахлах мэргэжилтэн*

Төслийн анхны санаа нь СХД-ийн одоогийн нэгдсэн эмнэлгийг 50 ортой өргөтгөл нэмж барих, тоног төхөөрөмжөөр ханган, удирдлагын шинэлэг тогтолцоог нэвтрүүлэхээр тусгасан байв. Монгол улсын Их Хурал 2011 оны 5 дугаар сард “Эрүүл мэндийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, нэгдсэн эмнэлэг нь багадаа

7 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байхаар тусгасан нь нэгдсэн эмнэлгийн үзүүлэх тусламж үйлчилгээний стандартыг үлэмж хэмжээгээр дээшлүүлсэн тул тухайн үеийн төслийн хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлын санхүүжилт нь энэхүү шаардлагыг биелүүлэхэд хүрэхгүй болсон юм. Шинэ хуулинд заасан шаардлагыг хангах, эмнэлгийн хуучин барилгын нөхцөл байдлыг харгалзан Засгийн газар хуучин эмнэлгийн барилгыг өргөтгөн засварлахын оронд шинээр эмнэлэг барих нь илүү үр ашигтай хэмээн үзэж төслийг өргөжүүлэхээр нэмэлт санхүүжилт авах хүсэлтийг гаргажээ.

“АХБ саналыг хүлээн авч, шаардлагатай нэмэлт санхүүжилтийг зөвшөөрсөнөөр энэхүү төсөл “4+” гэдэг тодотголтой болсон юм.”.

Улмаар, 3 дах шатлалын эмнэлгийн ачааллыг бууруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг ахиулах, эмнэлгийг барилга угсралт, эмнэлгийн болон эмнэлгийн бус

тоног төхөөрөмжийн нэр төрөл, хүчин чадал, эмнэлгийн төлөвлөлт, боловсон хүчин, тусламж үйлчилгээний төрөл гэх мэт бүхий л талаараа жишиг байж чадах дүүргийн эмнэлгийг СХД-ийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байгуулахаар болсон юм. Үндсэн мэргэжлийн буюу төрөх, эх барих эмэгтэйчүүд, мэдрэл, гэмтэл, мэс засал, халдвар, хавдар, хөнгөвчлөх гэх мэт бүх үйлчилгээг дүүргийн түвшинд үзүүлдэг байх шинэ загварыг гаргаж түүнийгээ жишиг болгон барих болсон нь ийм байвал зохистой юм гэдгийг харуулах гэсэн хэрэг. Гэхдээ...

ЯАГААД СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ГЭЖ?

Үндэсний статистикийн хорооны 2021 оны 1 дүгээр сарын нэгний өдрийн мэдээллээр СХД нь 94.132 өрх, 335,703 хүн амтай. Өөрөөр хэлбэл, Монгол улсын нийт хүн амын 10 хүн тутмын нэг нь, нийслэлийн хүн амын 3 хүн тутмын нэг нь тус дүүрэгт амьдардаг. Нийт 124.362.1 га нутаг дэвсгэртэй, 43 хороотой, Улаанбаатар хотын хамгийн том захын дүүрэг. Шилжин ирэгсэд ихтэй. Өвчлөл ч их. Тухайлбал, 0-16 хүртэлх насныхны дунд өвлийн улиралд ханиад томууны өвчлөл их байдаг бол насанд хүрэгчдийн дунд ходоод болон элэгний хорт хавдар, чихрийн шижин гээд халдварт бус өвчлөл зонхилдог. Энэ бүхэн нь агаар орчны бохирдлоос гадна

иргэдийн эрүүл мэндийн боловсрол тааруу, амьдралын буруу дадал хэвшил, эрүүл бус хооллолт гээд олон хүчин зүйлээс шалтгаалж байгааг эмч нар ярьдаг.

“Монгол Улсын Үндсэн хуульд улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй гэсэн заалтын дагуу иргэд оршин суух хөдөлгөөнд чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг 1992 онд бүрдүүлсэн билээ. 1990 онд Улаанбаатар хотын хүн ам нийт Монгол Улсын хүн амын 26 хувь байсан бол 2017 онд 47 хувь болон өсөж төвлөрөл нэмэгдсэн байна”.

ЭХЛЭЭД БҮГДИЙГ ТӨЛӨВЛӨВ

Төслийн эхний ажил нь СХД-т жишиг нэгдсэн эмнэлгийг олон улсын жишиг, стандартын дагуу барьж байгуулах байв. Гэтэл тухайн үед Эрүүл мэндийн байгууламжийг барьж, байгуулахад баримтлах Барилга хот байгуулалтын сайдын баталсан, хуучин Зөвлөлт холбоот улсын стандартад суурилсан, орон зайд тулгуурласан журмыг эс тооцвол Монгол улсад баримталдаг орчин үеийн шаардлага хангасан эмнэлгийн

барилгын стандарт байсангүй. Тиймээс, төслийн баг СХДНЭ-ийг хуучин стандартаар бус олон улсын зөвлөхүүдийн зөвлөснөөр олон улсад эмнэлгийн байгууламжийг ямар үе шаттайгаар, хэрхэн барьж байгуулахыг судалсан байна. Улмаар, Клаудио Мейрович гэдэг зөвлөхийн удирдлаган дор СХД-ийн хүн амын тоо, өвчлөлийн байдал, насжилт, мөн тухайн орон нутгийн байршил гэх бүхий л талаас нь судалж үзсэний үндсэн дээр СХДНЭ ямар

хүчин чадалтай байх, хэдэн хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, түүнтэй уялдсан хэдэн өрөө тасалгаа, ямар зай талбайтай байх, эрүүл ахуйн ямар стандартуудыг хангасан байх гэх мэт шаардлагатай бүхнийг тооцоолж, төлөвлөжээ. Нэмээд, эмнэлэгт байх эмнэлгийн болон эмнэлгийн бус, мэдээллийн технологийн бүх тоног төхөөрөмж, эд хогшлын жагсаалт, нэр төрөл, загвар, хүчин чадал, үнэ зэргийг цогцоор нь төлөвлөсөн байна.

СХД-ИЙН ЖИШИГ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙГ БАРЬЖ БАЙГУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ:



СХДНЭ-Н БАРИЛГЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ

2011

ЭМСХХ 4, 4+ төсөл эхлэв.

2013

Эмнэлгийн ерөнхий төлөвлөлт, схем зургийг Голланд улсын "Симед" компани боловсруулж эхлэв. Энэ ажлыг 2 үе шаттайгаар хийдэг ч СХДЖНЭ-н

хувьд 3 үе шаттай хийсэн. Симед компани урьдчилсан төлөвлөлтийн зургыг гаргасны дагуу техникийн болон ажлын зураг төслүүд хийгдсэн.

2014

Барилга баригдах газарт инженер, геологийн судалгаа, орчны зураглалыг хийв.

2014

250 ортой эмнэлэгт байх шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн төрөл, тоог тодорхойлсон. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг тухайн эмнэлгийн эмнэлзүйн тусламж үйлчилгээний онцлог, хүчин чадал, үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн болон тухайн орон нутгийн хүн амын тоонд үндэслэн тооцоолж гаргасан.

2015

Захиалагч барилгын зургийн даалгаварыг зургийн зохиогчид өгсөн.

2015

Эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл, төсвийг Солонгос улсын "Жунглим" компани боловсруулав.

2016

Эмнэлгийн барилгын
эскиз зураг батлагдав.

2017

Эмнэлгийн барилга угсралт, дэд бүтэц шаардсан эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр Австри улсын "Вамед Инженеринг" компани сонгогдсоноор барилгын ажил эхлэв.

2017

Эрүүл мэндийн яам, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хооронд Захиалагчийн хяналтын гэрээ байгуулагдав.

2017

Техникийн барилга, А, Б блок, подиум, зоорийн давхрын (суурийн цутгалт арматурчлал, хана, хамар хана, хучилтын цутгалт) барилга угсралтын ажил дууссан.

2017

Эмнэлгийн барилгыг зүүн тийш 7, хойшоо 3 метр тус тус шилжүүлсэнтэй холбоотойгоор эмнэлгийн барилгын ерөнхий төлөвлөгөөг Улаанбаатар хотын ерөнхий архитектороор шинэчлэн батлуулсан.

2017

Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдож барилгын ажил түр зогссон.

2018

Эмнэлгийн барилгын бүтээцийн ажлын зургийг Монголын Бюдингс Текноложи компани хийж гүйцэтгэв. Мөн тус компани нь эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн техник үзүүлэлтүүдийг эцэслэн боловсруулахад оролцсон.

2018

Эмнэлгийн барилгын ерөнхий төлөвлөгөөнд түргэн тусламжийн барилгын хэсэг төлөвлөгдөөгүй байсан тул шинээр нэмж, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан.

2019

Эмнэлэгт шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, тавилга бусад дагалдах шаардлагатай бараа бүтээгдэхүүний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 5 тендерыг зохион байгуулсан.

2019

Эмнэлгийн нэмэлт орц гарцтай холбоотой шинээр хийгдэх замын ажлын зураг төслийн даалгавар болон авто зам, замын байгууламжийн схем зураг, авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаварыг үндэслэн гүүрийн ажлын зургийн даалгавар батлагдсан.

2020

Тус оны 4 дүгээр сард автомашины орц гарц, зам гүүр, зогсоолын ажил эхэлж, 11 дүгээр сард дууссан.

2020

Улсын комисс эмнэлгийг барилгыг 11 дүгээр сард, зам, гүүр, зогсоолыг 12 дугаар сард хүлээн авсан.

2019-
2021

Ханган нийлүүлэгч байгууллагууд гэрээнд заасан үүргийн дагуу бараа, бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлж, угсралт суурилуулалт хийж, зохих сургалтуудыг чанартай хийж гүйцэтгэн хэрэглэгч байгууллагад албан ёсоор хүлээлгэж өгөв.

2021
5.11

СХДЖНЭ албан ёсоор нээгдэв.

БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ

СХД-ийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдсан 17.000 метр квадрат талбайтай СХДНЭ-ийн зураг төслийг Солонгосын “Жунлим” компанитай хамтран Монгол улсын “EZT” болон “Бюлдингс Техноложи” компаниудын хамтарсан консерциум хийж гүйцэтгэсэн юм.

“Бюлдингс Техноложи” компани олон улсын стандартын дагуу баригдах СХДНЭ-ийн зургийг орчин үеийн эмнэлгийн үйлчилгээ ямар байх ёстой тэр стандартуудад тохируулж гүйцэтгэсэн бөгөөд тэдэнд тулгарсан бэрхшээл нь мөн л Монгол улсын эмнэлгийн барилга байгууламж барих норм дүрэм шинэчлэгдээгүйтэй холбоотой байв. Зургийн ажлаас гадна барилгын зураг зохиогчийн хяналтын гэрээний дагуу барилга угсралтын ажлын эхний өдрөөс эхлээд дуустал нь зургийн зохиогчийн хяналтыг өдөр бүр тавьж ажилласан. Энэ нь нэгд, барилга зургийн даалгаврын дагуу буюу батлагдсан зураг төслийн дагуу баригдаж буй эсэх, хоёрт, захиалагчийн бүх хүсэлт, даалгаварууд бодит байдалд биелэлээ олсон эсэх, гуравт, барилгын ажил зураг төслийн батлагдсан төсөвт өртгийн хэмжээнд хийгдсэн эсэхийг хянадаг ач холбогдолтой.

Барилгын зургийг батлуулах үед эмнэлгийн байгууламжийг барих олон улсын стандарт Монголын барилгын салбарт нэвтрээгүйгээс болж дээрх боловсруулсан барилгын зураг төслийг үнэлэх, батлах үндэсний компани байсангүй.

СХДНЭ-ИЙН БАРИЛГА УГСРАЛТ

Австри улсад төвтэй, дэлхийн 95 улсад салбартай, 900 гаруй эрүүл мэндийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн, түүн дотроо эмнэлэг, эмнэлгийн барилга байгууламж барьж ашиглалтанд оруулсан 40 жилийн туршлага, мэдлэгтэй Вамед Инженеринг компани АХБ-ны санхүүжилтээр, олон улсын Фидик гэрээний⁵ ягаан номоор 250 ор бүхий 24.000 метр квадрат талбайтай СХДНЭ-ийн барилгыг барих болон эмнэлгийн болон эмнэлгийн бус 154 орчим нэр төрлийн 2000 гаруй тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажилд ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан юм.

Барилга угсралтын ажил 2017 оны 5 дугаар

⁵ “ФИДИК гэдэг нь зөвлөх инженерүүдийн олон улсын холбоо гэсэн үгний товчлол бөгөөд 1913 онд Европт байгуулагдсан ба одоогоор дэлхийн 70 гаруй гишүүн орнуудыг эгнээндээ нэгтгэсэн, бие даан үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Гол зорилго нь аливаа гэрээт ажлын нөхцлүүд болон гүйцэтгэгч, захиалагчийн хүлээх үүргийг тодорхой болгох, гэрээний ойлгомжгүй, тодорхойгүй заалтуудаас үүсэх маргаанаас

**Б. ТҮМЭННАСТ**

Бюлдингс Технологи компанийн
Гүйцэтгэх захирал, Цахилгаан
хангамжийн зөвлөх инженер

“Олон улсын эмнэлгийн барилгын стандартуудыг хангасан, эмнэлгийн менежментийн системийг нэвтрүүлсэн, дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын иж бүрэн зураг төслийг Монгол компаниуд анх удаа хийж гүйцэтгэсэн гэдгээрээ тун олзуурхууштай бас онцлог төсөл гэж би хувьдаа дүгнэдэг. Аливаа шинэ зураг төслөөс зургийн гүйцэтгэгч их зүйлсийг сурч, мэдэж авдагыг адилаар энэ төсөл дээр ажилласнаар бид эмнэлгийн зураг төслийг хамгийн орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэйгөөр хэрхэн төлөвлөх тал дээр олон зүйлсийг сурч, туршлага, мэдлэгээ зузаатгасан. Дараа нь үүнтэй төстэй зураг зурахад, заавал гадны зөвлөх компаниудыг урт хугацаагаар, өндөр өртөгөөр хөлслөх шаардлагагүй. Энэхүү жишиг эмнэлэгийн зургийг дараа дараагийн эмнэлэг барихад ашиглах бүрэн боломжтой бөгөөд ингэснээр цаг хугацаа, мөнгө хэмнэх давуу талтай. Үндэсний мэргэжилтнүүдэд итгэж, биднээр зураг төслөө хийлгэсэн, АХБ, ЭМСХХ 4, 4 + төслийн менежментийн багт талархаж байна”.

сарын 24 өдөр гэрээ байгуулснаар эхэлсэн бөгөөд хэсэг хугацаанд газар чөлөөлөлт болон барилга барихтай холбоотой зөвшөөрөл, бэлтгэл ажлууд хийгдсэний дараа 2017 оны

8 дугаар сарын 31-ний өдөр барилгын ажил эхэлсэн.

СХДНЭ-ийн барилга угсралтанд олон улсын болон дотоодын олон чадварлаг зөвлөх,

зайлсхийж, гэрээ, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох явдал юм”.



СХДЖНЭ-н барилгын ажлын явц



СХДЖНЭ-н барилгын ажлын явц

мэргэжилтнүүд ажилласан. Жишээ нь Орос, Герман, Австрийн инженерүүдийг дурьдаж болно. Салхивч, агааржуулалтын ажлыг Герман болон Оросын холбооны улсын инженерүүд хийсэн бөгөөд олон улсын эмнэлгийн стандартын дагуу агаарыг сорох, авах, өгөх гэсэн үйлдэлтэйгээр хийж гүйцэтгэсэн.

Барилгын ажлыг анхны гэрээ ёсоор 730 хуанлийн өдөр буюу 2019 оны 12 дугаар сард дуусгах төлөвлөгөөтэй байсан. Хэдийгээр, төсөл хэрэгжиж явцад, барилгын ажлын зураг дутуу боловсруулагдсан байсантай холбоотойгоор хугацаа алдсан ч төсөл хэрэгжүүлэгч нэгж

оролцогч талуудын уялдаа холбоог сайтар хангасны үр дүнд барилгын ажлыг харьцангуй хурдан хугацаанд гүйцэтгэж чадсан.

Төсөлд тулгарсан гол бэрхшээл болох Ковид-19 цар тахлаас болж, гаднаас ирэх ёстой байсан инженер, мэргэжилтнүүд саатах, зарим тоног төхөөрөмж, барилгын материалын хомсдол үүсч, тоног төхөөрөмжүүд хугацаандаа үйлдвэрлэгдэж чадахгүй байх зэргийг дурьдаж болно. Үүнтэй холбоотойгоор, гэрээний хугацааг сунгаж, СХДНЭ-ийн барилгыг тоног төхөөрөмжийн хамт 2021 оны 3 дугаар сарын 31-нд ашиглалтанд оруулсан юм.



СХДЖНЭ-н барилгын ажлын явц



Вамед Инженеринг компани барилгын ажлаас гадна эмнэлгийн зарим том тоног төхөөрөмжийг ханган нийлүүлсэн. Барилга угсралтын компанид энэ ажлыг давхар оноосон нь тохиолдлын шийдвэр биш юм. Эмнэлэгт дурын газар байрлуулах боломжгүй, байрлуулбал зохих газартаа цахилгаан, ус, бохир зайлуулах гэх мэт инженерийн дэд бүтэц шаардлагатай тоног төхөөрөмжүүд байдаг. Ийм тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, суурилуулах ажлыг барилга угсралтын гүйцэтгэгчээс тусад нь гэрээлсэнээр, барилгад тохирохгүй тоног



төхөөрөмж нийлүүлэх, нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг суурилуулахын тулд барилгын дотор засал, дэд бүтцийг эвдэх, нураах гэх мэт эрсдэлүүд гардаг. Гэтэл СХДНЭ-ийн барилгын хана, шал зэрэг нь туяаны хамгаалалттай, бактер үрждэггүй, олон зуун удаагийн угаалтыг тэсвэрлэдэг тусгай материалаар хийгдсэн буюу товчхондоо барилгын болон дотор заслын үнэтэй ажил, материалыг уялдаагүй ажлын алдаанаас болж эвдэлж, илүү зардал гаргахаас сэргийлэхэд гэрээний энэ шийдэл тус болжээ.



Шинэ технологи, өндөр чанартай, 64 зүсэлттэй компьютер томографийн аппаратыг суурилуулах, ашиглалтад оруулах, тухайн өрөөний засвар, холбогдох инженерийн шугам сүлжээний холболтуудыг "Вамед инженеринг компани" хийсэн бөгөөд ингэхдээ технологийн байгуулалтын зургаас нь эхлээд барилгын карказ угсралт, суурийн цутгалтын явцад бүгдийг сайтар тооцсон. Энэ аппарат их хүнд жинтэй учраас суурийг цутгахдаа 400 маркийн өндөр чанартай бетон ашигласан.



Вамед Инженеринг компани энэ төслийн ерөнхий гүйцэтгэгчээр ажиллахдаа туслан гүйцэтгэгчээр Монгол компаниудыг авч ажиллуулсаны үр дүнд, Монголын инженер, мэргэжилтнүүд Вамед Инженеринг компанийн гадаад мэргэжилтнүүдээс олон зүйлсийг сурч, мэдэж авсан. Энэ нь тэднийг дараа дараагийн ижил хэмжээний төсөлд оролцоход мэдлэг, туршлага, ур чадвар болно гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

БАРИЛГЫН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

Эрүүл мэндийн сайд болон Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаалаар тус эмнэлгийн барилга угсралтын ажил, инженерийн шугам

сүлжээ, дэд бүтэцтэй холбоотой асуудлуудад мэргэжлийн түвшинд зөвлөмж зөвөлгөө өгөх зорилго бүхий ЭМЯ, НХОГ, НЭМГ, НЕТГ, УСАГ, дулаан, цахилгаан эрчим хүч, холбооны хангагч байгууллагуудын бүрэлдэхүүнтэй Барилгын дэд ажлын хэсэг байгуулагдсан нь барилга угсралтын явцад тулгарсан олон улсын эмнэлгийн барилгын технологи, стандартын шаардлага түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, салбар хоорондын ажлыг уялдуулан төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд онцгой ач холбогдолтой байлаа.

Барилга угсралтын талбайн суурийн ажил эхлэхэд төслийн талбайн урд талд байрлах орон сууцны байр төсөл хэрэгжих талбайн кадастрын зурагтай давхацсан байсан нь гэнэтийн асуудал байлаа. Жишиг нэгдсэн эмнэлгийн газар олголт, түүн дээр барилга барих зөвшөөрөл 2009 онд гарсан боловч 2015 онд уг газарт орон сууцны барилга барих зөвшөөрөл олгогдсон байжээ. Хэрэв эмнэлгийн барилгыг барьсан бол орон сууц ба эмнэлэг хоёрын дунд 3 метрийн зай үлдэх байв.

Хэдийгээр, орон сууцны барилгын газрыг давхардуулж олгосон байлаа ч орон сууц нэгэнтээ баригдаж, оршин суугчид нь амьдарч байгаа нөхцөлд төслийн багийнханд өөр


шийдэл хэрэгтэй болсон юм. Тэгээд ч АХБ-ны хамгааллын журмаар АХБ-ны санхүүжилттэй төсөл хэрэгжсэнээс болж хэн нэгний амьдрал муудаж доройтож, хохирох ёсгүй байдаг. Тиймээс тухайн үед газар дээр нь хуралдаад Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын холбогдох мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үр дүнд, архитектур төлөвлөлтийн даалгаврыг өөрчилснөөр барилгыг хойш нь 3 метр, зүүн тийш нь 7 метр шилжүүлж, улаан шугамыг тавьсан байна.

Улаан шугам ингэж тавигдсанаар дараагийн асуудал гарч ирэв. Хуучин нэгдсэн эмнэлгийн бохирын шугамтай шинээр барих барилгын трас давхацсан байлаа. Улмаар бохирын шугамыг шилжүүлэх шаардлагатай болсон. Энэ ажлыг богино хугацаанд амжилттай хийж дуусган, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсний дараа суурийн ажлыг эхлүүлэв. Суурийн ажил намрын сэрүү унаж байх үед эхэлсэн буюу 4 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд үргэлжилдэг Монголын барилгын улирал дуусахад 2 сарын богино хугацаа үлдээд байсан юм. Энэ богино хугацаанд 6000 метр квадрат барилгын суурийн ажлыг цутгахын тулд Монгол улсын олон зөвлөх болон гавьяат инженерүүдтэй зөвлөлдсөний эцэст барилгын техникийн блокийн хэсгийг цутгая гэсэн шийдэлд хүрсэн байна. Нийт суурийг ухахад хөрс

овойж хөлдөх, гэсэх, гэссэний дараа эргээд суух зэрэг хүндрэлүүд үүсч байжээ. Улмаар, барилгын суурь доошоо 5.6 метр, нил суурьтайгаа нийлээд 7 метр орчим гүн ухлага хийж, суурийн цутгалтын ажлыг 11 дүгээр сарын 24-ны өдөр амжилттай хийж дуусгасан.

Барилга угсралтын баг 2018 оны 5 дугаар сард магадлалаар баталгаажсан иж бүрэн ажлын

зурагтай болсон байлаа. Ажлын зураг хэдий бэлэн болсон ч эмнэлгийн барилгын хувьд бусад барилгаас ялгаатай онцлог нь эмнэлгийн урсгал гэдэг зүйлийг барилгын архитектурт зөв, сайн тусгаж өгсөн байх ёстой байдаг аж. Энэ ажлыг “Вамед инженеринг” болон “Магнус сентурион констракшн” компанийн хамт олон мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэсэн юм.



АВТОЗОГСООЛЫН ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ

Засгийн газраас дүүргийн хэмжээнд оршин суугчдад эмнэлгийн үйлчилгээг өргөжүүлэх, ялангуяа хүүхдийн өвчлөлийг бууруулах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор эмнэлгийн хуучин барилгыг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор нэмэлтээр зам, гүүрийн ажил хийгдэх болсон юм. АХБ-ны дэмжлэгтэйгээр Газар чөлөөлөлт,

нүүлгэн шилжүүлэлтийн ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргаж, Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай хамтран хэрэгжүүлжээ.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/160 захирамжаар Нийслэлийн засаг даргын орлогчоор ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг баталж, ажлын хэсгийн хурлаас зохих шийдвэрүүдийг гаргаж, хяналт тавьж ажилласан. Газар чөлөөлөлт нүүлгэн



шилжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 6 дугаар сард шинэчлэн боловсруулж, нөхөн олговрыг нөлөөлөлд өртсөн иргэдэд олгуулахаар шийдвэрлэсэн юм.

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд Сонгинохайрхан дүүргийн 4, 19 дүгээр хорооны нийт 17 нэгж талбарын 1731 м² зөвшөөрөлтэй, 1411 м² зөвшөөрөлгүй газар нөлөөлөлд өртсөн. Нөлөөлөлд 6 иргэний газар бүтэн, 14 иргэний газар хагас өртөж, улмаар Газар зохион байгуулагч нар, төслийн зөвлөх нөлөөлөлд өртсөн айл өрхийн иргэдтэй тусгайлсан уулзалтуудыг газар дээр нь, хорооны байранд болон Нийслэлийн газар зохион байгуулалтын Газар чөлөөлөлтийн хэлтсийн байранд тус тус хийж, гарын авлага тарааж, холбогдох мэдээллээр хангаж, иргэдээс ирүүлсэн гомдол, саналыг хүлээн авч, шат шатанд нь шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажилласан юм.

Нөлөөлөлд өртсөн иргэдийн санал бодлыг судлахад, цөөн хүмүүс эзэмшиж буй газрын хэмжээ нь багасч байгаа, дуу чимээ нэмэгдэх сөрөг талтай гэж үзэж байсан бол дийлэнх нь амьдрах орчин сайжирна, тоосжилт багасч агаарын бохирдол буурна, гудамжны гэрэлтүүлэг нэмэгдэнэ, эмнэлгийн үйлчлүүлэгчдэд эмнэлэг рүү орох, гарахад саадгүй болох боломж бүрдэнэ гэсэн эерэг сэтгэгдэлтэй байлаа.

Нөлөөлөлд бүрэн өртсөн иргэд, түрээслэгчдийн 83,3 хувь нь амьжиргааны түвшингээс доогуур амьдралтай айл өрхүүд эзэлж байсан тул Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас газрын зөвшөөрөлгүй 3 иргэнд дүүргээс газрын гэрчилгээг гаргуулан өгч, нөхөн олговрыг олгохоор шийдвэрлэсэн юм. Нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийн газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг Барилгын төсөв хөрөнгийн үнэлгээний “Бэсгэ”, “Fairvaluation” компани тус тус гүйцэтгэж, нийт 288,539,459 төгрөгийн нөхөн олговрыг иргэдэд олгуулахаар шийдвэрлэжээ.


Нийслэлийн газар зохион байгуулалтын алба 2020 оны 5 дугаар сараас эхлэн нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийг нөхөн олговортойгоор чөлөөлөх ажлыг эхлүүлж, Газар чөлөөлөлтийн нөхөн олговорт Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/799 тоот, А/1061 тоот болон 2021 оны 6 сарын А/518 захирамжуудаар баталсан, нийт 289,965,352 төгрөг (101,742.229 ам доллар)-ийг олгожээ. Газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэх явцад гэрээт компани 2020 оны 3 дугаар сараас гүүрний ажлыг эхлүүлэн улмаар 2021 оны 10 дугаар сард эмнэлгийн нэмэлт орц, гарц, гүүр, зогсоолын ажлыг бүрэн гүйцэтгэж, жишиг эмнэлэг ашиглалтад орохоос өмнө улсын комист хүлээлгэн өгчээ.



Нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийн хамрах хүрээ

ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ БЭРХШЭЭЛ

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа нь удаашралтай, саад бэрхшээлтэй явагдсан гол шалтгаан нь энэ ажил урьдчилан төлөвлөгдөөгүй байсантай холбоотойн дээр хөрөнгө санхүүжилтийн асуудал төсөвт тусгагдаагүй, асуудал хариуцсан газар зохион байгуулагч нарын төслийн хүрээнд газар чөлөөлөх талаарх мэдлэг мэдээлэл хангалтгүй, АХБ-ны хамгааллын бодлого нь манай улсад хэрэгжиж буй газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, дүрэм журамтай зөрчилдөж байсан нь нөлөөлсөн юм. Иймээс дараагийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдэх газар чөлөөлөлтийн ажлыг урьдчилан төлөвлөж, төсвийн төлөвлөлтөд оруулах, Газар зохион байгуулалтын албаны удирдах ажилтнуудад нөлөөллийн үйл ажиллагааг явуулах, бодлогын зөрүүтэй байдлыг бууруулах чиглэлд төрийн байгууллагаас анхаарч, үе шаттайгаар бодлогын шинэчлэл хийх, газар зохион байгуулагч нарыг төслийн сургалтад хамруулах, эмзэг бүлгийн хүмүүсийн нөхөн олговрын асуудлыг онцгойлон үзэж амьжиргааны түвшинг бууруулахгүй байх, нийтийн орон сууцаар хангах, зээл тусламжид хамруулах чиглэлд анхаарч ажиллах нь зүйд нийцнэ.



Газар чөлөөлөлтийн хамралт ба зам, гүүр, зогсоолын байршлын зураг



Замын ажлын явц



СХДНЭ-ИЙН АВТОЗОГСООЛ, НЭМЭЛТ ЗАМ, ГҮҮР, ОРЦ ГАРЦ

Эмнэлгийн барилгын ажил дээр нэмэгдэн, 2,6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтээр зам, гүүр, зогсоолын ажил хийгдсэн.

Хуучин байсан СХД-ийн эмнэлэг рүү Толгойтын замаас ордог 1 орц, гарцтай, зорчих хэсгийн нөхцөл байдал нь эрсдэл өндөртэйгээс гадна автомашины зогсоол хангалтгүй байсан тул автозогсоолын тоо болон автомашины орц гарцыг нэмж урсгалыг чөлөөтэй болгох, эмнэлгээр үйлчлүүлэгчдийн зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс дээрх ажил хийгдсэн.

Мөн нийслэлийг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан эмнэлгийн баруун тал болон далангын баруун талын газрыг эзэмшиж байгаа айлуудын судалгааг хийж тухайн байршил дээр амьдарч байгаа иргэдтэй зөвшилцөж нүүлгэн шилжүүлэлт хийсэн. Түүнчлэн, төслийн ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан зам, гүүр, зогсоолыг төлөвлөхөөр болж мэргэжлийн зөвлөх багийг шалгаруулан авч ажиллуулан ТЭЗҮ хийлгэн зураг, төсвийг холбогдох байгууллагуудаар батлуулж тендер зарлан гүйцэтгэгчээр “ЗМЗ” ХХК-ийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлжээ.



Х. ЧУЛУУНБААТАР

ЭМСХХ 4 төслийн Барилгын хяналтын инженер

Энэ нэмэлт ажлын хүрээнд нийт замын 2 талаар гэрэлтүүлэг бүхий 760 метр урт, зорчих хэсэг нь 4-8 метр өргөн авто зам, 32 метр урт, 8 метрийн өргөнтэй төмөр бетонон гүүр, зам, гүүрийн 2 талаар 1,5 метрийн өргөнтэй явган зам, 130 метрийн урттай 28 метрийн өргөнтэй, 7 байршилд ус зайлуулах байгууламж, гэрэлтүүлэг бүхий 100 автомашины зогсоолыг барьж байгуулсан. Ингэснээр нийт 200 автомашины зогсоол, 2 талаар орох орц, гарцыг шийдэж өгсөн юм.

Энэ бүтээн байгуулалтын ажлын хүрээнд, эмнэлгийн зүүн урд талын 5-6 метрийн өргөнтэй байсан хороолол дундах замыг өргөтгөж 8 метрийн өргөнтэй болгосон. Мөн баруун талын даланг давуулж гүүр барьж гэр хорооллын гудамжийг хойшоо Толгойтын замд холбосон Монгол улсын зам, барилгын норм, дүрэм, стандартад нийцсэн замыг шинээр хийсэн.

Зам, гүүр, зогсоолын барилгын ажилд НАЗХГ (Нийслэлийн Авто Замын Хөгжлийн газар)-ын хяналтын инженерийн баг техник хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Энэ ажлын үр дүнд, эмнэлгээр үйлчлүүлэгчдээс гадна эмнэлгийн ойр орчимд амьдарч байгаа иргэдийн замын хөдөлгөөнд аюулгүй оролцох,



В. ГАНТУЛГА

Магнус Сентурион Констракшн компанийн Гүйцэтгэх захирал

“Вамед инженеринг” компани дэлхийн 49 оронд олон улсын эмнэлгийн төслүүдийг хэрэгжүүлдэг туршлагатай компани юм. Энэ компанийн туршлагатай инженер Монгол улсад ирж ажиллаж, түүнээс суралцах боломж олдсон нь тун завшаантай. Манай компанийн инженерүүд болоод энэ төсөлд оролцсон олон туслан гүйцэтгэгч компаниуд их зүйл сурсан гэдэгт итгэлтэй байна. Энэ утгаараа ЭМСХХ 4 төсөл Монголд нэг барилга бариад үлдээх биш Монголын инженерүүд хөгжих, шинэ шатанд гарах боломж, туршлага болсон сайхан төсөл болсон. Ер нь туршлага гэдэг маш том хөрөнгө юм. Олон улсын төсөл дээр ажилласны үр дүнд бидний авсан туршлага удирдлагын хувьд ч, менежментийн багийн хувьд ч, байгууллагын соёлын хувьд ч эерэг нөлөөллийг үзүүлсэн. Манай байгууллага шинээр бий болсон ур чадвар, туршлага, амжилт, шинэ арга барилаа улам хөгжүүлж, өөриймшүүлэн хадгалан ажиллах болно”

цэвэр орчинд зорчих боломж бүрдсэн учир чухал ач холбогдолтой бүтээн байгуулалт болсон гэж дүгнэж болно.

БНСУ-аас компьютер томографийн аппаратыг суурилуулах инженер техникийн ажилтнууд ковидоос болоод ирэх боломжгүй болсон юм. Нэгэнт байдал ийм болсон тул Монголоос энэ төхөөрөмжийг суурилуулах чадварлаг

багийг хайж олох сорилт тулгарчээ. Улмаар, эмнэлгийн тоног төхөөрөмж суурилуулалтаар 10 гаруй жил ажилласан туршлагатай, эмнэлгийн тоног төхөөрөмжийн 23 инженер, техникийн мэргэшсэн ажилтантай “Сетунари” ХХК-ийн монгол инженерүүд СХДНЭ-ийн компьютер томографийн аппаратыг Монголд анх удаа суурилуулж, амжилттай хүлээлгэж өгсөн нь бахархуштай.



**Б.ЦЭНДАЮУШ**

*ЭМСХХ Төслийн Барилга, худалдан авалт
хариуцсан мэргэжилтэн*

СХДНЭ-т зохистой дизайн, засвар үйлчилгээтэй, гүйцэтгэлийн өндөр стандартыг 24 цагийн турш хангасан, орчин үеийн технологи бүхий халаалт, агаар сэлгэлтийн системийг угсарч

суурилуулсан нь эмгэг төрүүлэгчдийг агаараар дамжих эрсдлийг бууруулах, үйлчлүүлэгч ба ажилтнуудыг халдвараас хамгаалах, өвчтөний эдгэрэлтийн орчинг бүрдүүлэхэд халдвар хамгааллын нэн чухал ач холбогдолтой шат ахисан ажил болсон билээ. Түүнчлэн, СХДНЭ нь галаас хамгаалах систем, автоматик, дохиолол зэрэг нь олон улсын эмнэлгийн стандартад нийцсэнээр эмнэлгийн блокоос блок руу гал дамжихгүй, инженерийн шугам сүлжээ болон ажилтан, ажилчид, үйлчлүүлэгчид ба үлэмж үнэ цэнээр бий болсон үл хөдлөх хөрөнгийг галын аюулаас бүрэн хамгаалах чадвар бүхий инженерийн системтэй. Инженерийн нарийн ур чадвар шаардсан дээрх хоёр шинэлэг системийг дүүргийн нэгдсэн эмнэлэгт нутагшуулж, ашиглаж эхэлсэн нь Монголын олон инженерүүдийн мэдлэгийг ахиулж, туршлагыг зузаатгасанд сэтгэл өндөр байгаа. Нэмээд хэлэхэд, барилгын ажлын гэрээ түүнийг тойрсон олон маргаантай асуудлыг даван туулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, талуудын хоорондын эрсдэл, эрх, үүргийг хамгийн шударгаар хуваарилдаг, нөхцлүүд нь ойлгомжтой, бүрэн зохицуулагдсан, барилга угсралттай холбоотой байж болох бүх л ажлын гүйцэтгэлийг зохицуулсан ФИДИК гэрээг хэрэглэсэн нь гэрээт ажил хугацаандаа амжилттай хэрэгжих нэг чухал үндэс болсон юм.

СХДНЭ-ИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Төслийн хүрээнд барьж байгуулсан 250 ортой СХДНЭ-т нийлүүлэгдсэн 25.000 орчим эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжүүд, бусад дагалдах тоног төхөөрөмжүүд нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг шингээсэн. Онцолж дурдахад, СХДНЭ-ийн ариутгалын тасагт Испани улсын Матачана группын өндөр хүчин чадалтай ариутгалын тоног төхөөрөмжүүд бий. Ингэснээр ариутгалын чанар сайжирч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлнэ. Мөн ариутгалын тасаг дах ажлын урсгалыг сайтар тооцоолж, төлөвлөсний дээр ариутгах ажилд хүний гар ажиллагааг багасгаж, автоматжуулсан зэрэг нь ариутгалын дараах халдварын эрсдлийг бууруулах давуу талтай.

Түүнчлэн, дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдэд компьютер томографийн үйлчилгээ дутмаг байдаг. СХДНЭ-т Siemens брэндийн Somatom go.ip загварын компьютер томографийн тоног төхөөрөмжүүд суурилуулагдсан. Ингэснээр, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулж, чирэгдэл

багатайгаар онош тодруулах, 3 дах шатлалын эмнэлэгт хийгддэг энэ төрлийн оношилгооны ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлж өгсөн.

Ариутгал, мэс заслын болон дүрслэл оношлогооны зарим төхөөрөмжүүд, хүчилтөрөгч агааржуулалтын нэгдсэн систем, угаалга, гал тогооны тоног төхөөрөмжүүдийн угсралт, суурилуулалтын ажлыг эмнэлгийн барилгын дэд бүтэцтэй нийцүүлэх шаардлагатай байдаг бөгөөд энэ ажлыг эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн Австрийн “Вамед инженеринг” компани өндөр түвшинд хийж гүйцэтгэн,






ашиглалтад оруулсан байна. Ийнхүү барилгын зургийн явцад тоног төхөөрөмжийг угсарч, суурилуулах шийдлийг зөв тооцоолж, уялдуулан зохион байгуулсанаар барилга баригдсаны дараа нэмэлт засвар, барилгын ажил хийх эрсдэлтэй тулгарахгүй байх давуу талыг бий болгодог билээ.


СХДНЭ-ийн нийт тоног төхөөрөмжүүдийг барилгын ажлын явцын төгсгөлд суурилуулж эхэлсэн бөгөөд угсралт суурилуулалтын ажлыг ханган нийлүүлэгч байгууллагууд чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хэрэглэгчийн буюу ашиглалтын болон тоног төхөөрөмжүүдийн техникийн талын сургалтуудыг тухай бүрт хийж байлаа.

СХДНЭ ЮУГААРАА ЖИШИГ ЭМНЭЛЭГ БОЛОВ?

Сонгинохайрхан дүүргийн 19 хорооны нутаг дэвсгэрт баригдсан дүүргийн нэгдсэн жишиг эмнэлэг А ба В блок, техникийн барилга гэсэн 3 үндсэн блокоос бүрдэх бөгөөд нийт 17.000м² талбай бүхий, 4 давхар барилга юм.

Төмөр бетон бүтээцтэй, 400мм-н хөнгөн блок дүүргэгч ханатай, 150мм полистирол хавтангийн тусгаарлагч дулаалгатай





250 орны хүчин чадалтай хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй.

Гадна фасад, барилгын дотор интерьер дизайн, дэд бүтэц, инженерийн хангамж нь олон улсад мөрдөгдөж буй орчин үеийн эмнэлгийн төлөвлөлттэй. Мөн 3126м² талбайд ногоон байгууламж бүхий тохижилттой орчинтой.



Анхны евростандартын эмнэлэг: Олон улсын эмнэлгийн стандартыг хангасан дүүргийн анхны эмнэлэг. Монгол улсад 1982 оноос хойш ийм хэмжээний талбай, иж бүрэн тоног төхөөрөмжтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга шинээр баригдаагүй юм.



Галын аюулаас бүрэн хамгаалагдсан: Галын хамгаалалтын инженерийн системийг олон улсын эрүүл мэндийн байгууллагын стандартаар хийсэн Монголын дүүргийн анхны эмнэлэг. Блокоос блок руу, давхараас давхар руу гал дамжихгүй байлгах галын автомат хаалт, хөшиг, хавтангуудтай. Бохирын шугам, хуванцар хоолой, цахилгааны болон холбооны кабелиуд гэх мэт инженерийн бүх шугам сүлжээг болон хамар хана, давхар хоорондын хучилт зэргийг галд тэсвэртэй, тусгаарлах материалаар бүрсэн.



Хана: 3000 удаагийн угаалтыг тэсвэрлэх чадвартай, бактери үрждэггүй будгаар будсан. Рентген туяаны хамгаалалттай тусгай зориулалтын хамгаалалтын хавтан ашигласан.

Шал: Цахилгаанждаггүй, бактери үрждэггүй хулдаастай.

Тааз: Галд шатдаггүй, бактери үрждэггүй материалтай.

Хамгаалалт: Хаалга, ханын хамгаалалт, бариулууд олон улсын эмнэлгийн стандартад нийцсэн материалтай.

Салхивч, агааржуулалтын систем: Гадагшлуулахаар соруулж буй бохир агаар гаднаас оруулж буй цэвэр агаартай холилдохгүй. Соруулж буй агаарын дулааныг дахин ашиглах эрчим хүчний хэмнэлттэй шийдэлтэй. Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтнуудад халдвар дамжихаас сэргийлсэн орчин бүрдсэн.



Хөргөлтийн систем: СХДНЭ-т суурилуулсан хөргөлтийн системтэй аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг өнөөдрийн байдлаар Монгол улсад хараахан байхгүй. Энэ системийг зочид буудлуудад түгээмэл хэрэглэсэн байдаг бөгөөд зун, намрын халуун өдрүүдэд ерөөний цонхыг онгойлгохгүйгээр эмчилгээ үйлчилгээ үзүүлэх тохиромжтой температурыг хадгалах боломжтой.

Ашиглалттай дэвэр: Эмнэлгийн дээврийг тохижуулсанаар үйлчлүүлэгч урт зам туулж, доошоо бууж, бусадтай хавьталгүйгээр амарч, салхилах боломжтой.





Дээврийн материал: Герман улсад Германы технологиор үйлдвэрлэгдсэн, цавуугаар наадаг, хэт хүйтэн температурт тэсвэртэй, 30-40 жилийн баталгаат хугацаатай, мембран материалаар дээврийн бүх талбайг бүрсэн Монголын анхны барилга.

Хүчилтөрөгчийн систем: Хэвтэн эмчлүүлэгч бүрийн орны дээд талд хүчилтөрөгчийн төхөөрөмжийг суурилуулсан. Хүчилтөрөгчийн системээр тоноглогдсон 250 ортой дүүргийн анхны бөгөөд цорын ганц эмнэлэг.





Барилгын удирдлагын нэгдсэн систем: Өвчтөнүүдийн өрөө тасалгааны салхивч, агааржуулалт, хүчилтөрөгч, гэрэл, дулаан, зарлан мэдээлэх, сувилагч дуудах, галын аюулгүй байдлын гэх мэт эмнэлгийн барилгад ажиллаж, ашиглаж байгаа 12 төрлийн системийг нэг цэгээс, автоматаар удирдах Барилгын удирдлагын нэгдсэн системтэй. Энэ нь цахилгаан, ус, хүчилтөрөгчийн хангамж тасалдахад автоматаар нөөцийн хангамжийн систем рүү шилжүүлэх, барилгын шугам хоолойд гарсан гэмтэлийг цаг алдалгүй илрүүлж, мэдээлэл өгөх, засвар үйлчилгээ хийх болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, өвчтөнд үзүүлэх эмчилгээ оношилгоог тасалдуулахгүй байх боломжоор хангадаг ухаалаг систем юм.





Ая тух: Эмчлүүлэгчдийн өрөө бүрт ариун цэврийн өрөөтэй, сувилагч дуудах системийг ор болон ариун цэврийн суултуурын дэргэд тоноглов.





Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автозогсоол, тэргэнцэр чөлөөтэй явах налуу хашлага, босгогүй гадна болон дотор хаалга, товгор хөтөчтэй зам, ариун цэврийн өрөө, тэргэнцэртэй хүмүүст тохирох стандартад байрласан гэрлийн унтраалга, цахилгаан шатны товчлуур, хана дагасан бариулыг давхар бүрийн хананд суурилуулсан. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн үзлэгийн орны өндрийг тэргэнцэрийн түвшинд тохируулах боломжтой.


Туяаны хамгаалалт: Дүрс оношлогоо, хагалгааны өрөөнүүд бүгд туяаны хамгаалалттай.



Авто зогсоол, нэмэлт орц гарц: СХДНЭ-ийн зам харилцаа, орц гарц, зогсоолыг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор, 2 талаараа гэрэлтүүлэг бүхий 760 метр урт, зорчих хэсэг нь 4-8 метр өргөн авто зам, 32 метр урт, 8 метрийн өргөнтэй төмөр бетонон гүүр, зам ба гүүрийн 2 талаар 1,5 метрийн өргөнтэй явган зам, 130 метрийн урттай 28 мөрийн өргөнтэй, 7 байршилд ус зайлуулах байгууламж, 100 автомашины гэрэлтүүлэг бүхий зогсоол, нийт 200 автомашины зогсоолыг хийсэн. Эмнэлэг 2 талаараа орох орц, гарцтай.



Аюулгүй цонх: Цонхоор юм шидэх, хүн унахаас сэргийлсэн салхивчтай.



Усан хангамж: Ус тасарсан үед 7 хоногийн хэрэгцээг хангах хүчин чадалтай усны нөөц савтай.

Цахилгааны эх үүсвэр: Тог тасарвал 5-8 секундын дараа эмнэлгийн шаардлагатай хэсгүүдийг цахилгаанаар хангах 750 кВт -ийн хүчин чадалтай, 500 литрийн түлшний сав бүхий, цагт 80-100 литр түлш зарцуулдаг дизель генератортой. Мөн нарны эрчим хүчийг ашиглан гадна гэрэлтүүлэг болон зарим бага чадлын тоног төхөөрөмжүүдийг цахилгаанаар хангадаг нарны эрчим хүчний станц нь 36 Вт-ын чадалтай 76 ширхэг нарны панельтай бөгөөд сард 1200-1800 кВт цахилгааныг үйлдвэрлэдэг.



А.МӨНХТАЙВАН

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх
нэгжийн зохицуулагч

ЭМСХХ-4, 4+ төслийг амжилттай хэрэгжүүлснээр, 160 сая долларын санхүүжилттэй, эмзэг бүлгийн эрүүл мэндийн асуудлыг дэмжих ЭМСХХ-6 төсөл батлагдах суурь, үндэслэл болж өгсөн юм. Түүнчлэн, СХДНЭ амжилттай баригдсанаар Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт жишиг нэгдсэн эмнэлгийг барихаар болсон”.

ЭМСХХ 4, 4+ төсөл анх удаа АХБ-ны шилдэг төслөөр шалгарсан нь тус төслийн хамт олны хичээл зүтгэлийн үр дүн байлаа.



Энэхүү батламжийг L2932/G0236-MON: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4+ болон L2963-MON: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 төслийн удирдлагын багт олгов. Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч Ёланда Фернандез Ломмен. 2019 оны 5 дугаар сарын 10. Улаанбаатар. Монгол улс





Н. ОЮУНБИЛЭГ

ЭМСХХ-4, 4+ төслийн дэд зохицуулагч

Аливаа төсөл, хөтөлбөр салбарын тулгамдсан асуудлыг иж бүрэн цогцоор шийдэхийг зорьж ажилладаг. Энэ удаагийн хэрэгжүүлсэн төсөл Нэгдсэн эмнэлгийн шинэ үзэл баримтлал, бодлого, дүрэм журам ямар байхаас эхлээд, барилга байгууламж, дэд бүтэц, зам харилцаа, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийг хэрхэн бэлтгэхэд чиглэж байлаа.

Төсөл зорьсон зорилгодоо хүрэхийн тулд тухайн тусламж үйлчилгээний хэрэгцээнд нийцүүлэн 30 гаруй эмч нарыг үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр, 40 гаруй сувилагчийг төрөлжүүлэн бэлтгэж, 50 гаруй туслах сувилагчийг төслийн хүрээнд боловсруулан сургалтын хөтөлбөрөөр бэлтгэв. Түүнчлэн уншиж судлах сурах бичиг, гарын авлагыг англи хэлнээс орчуулан, хэвлүүлэв.

Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах дүрэм журмыг олон улсын эмнэлгийн Зөвлөх баг боловсруулан, туршиж нэвтрүүллээ. Эрүүл мэндийн зах зээлд нэгдсэн эмнэлгийг удирдах, эмнэлгийн бүх шатны удирдах ажилтнуудыг эмнэлгийн менежер бэлтгэх сургалтанд хамруулан, гарын авлагаар хангав. Дэлхийн банк, АХБ-ны техник туслалцааны бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан, Нэгдсэн

эмнэлгийн стандарт, Магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах зорилгоор олон улсын практикт нэвтэрсэн Эмнэлгийн гүйцэтгэлийн олон нийтэд нээлттэй мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх ерөнхий концепци, хэрэглэх шалгуур үзүүлэлтүүд, хөрөнгийн төлөвлөлт, бүртгэл мэдээллийн програм хангамж, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэршлийн гарын авлага”, “Олон нийтийн онооны картаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх нь” гарын авлага, “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн санхүүгийн удирдлагын гарын авлага” зэрэг материалыг боловсруулан, хэрэгжүүлж, шилдэг туршлагуудыг нэвтрүүлэв. Ийнхүү нэгдсэн эмнэлэг ямар байх жишиг, загварыг бүрэн утгаар нь загварчилж, цогц байдлаар амжилттай хэрэгжүүллээ.

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН 2:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ХӨТӨЛБӨР 4, 4+



ЭМСХХ-4 төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын удирдлага зохион байгуулалтын эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийжээ.

2016 онд Эрүүл мэндийн хуулийн 25.12, 25.13 болон 25.16 заалтуудад эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалттай холбогдсон үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт болон санхүүжилтийн механизм, резидентын хөтөлбөрийн тэтгэлэг олгох асуудлыг, Эмнэлгийн тусламжийн хуулийн 22.1.7, 22.1.8, 22.2 болон 22.3 дугаар заалтаар резидент эмчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх зөвшөөрөл олгох, резидент эмчийн эрх, үүрэг болон резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмын талаарх зохицуулалтыг нэмэлтээр тусгайлан оруулж өгсөн байдаг.

Түүнчлэн, төгсөлтийн дараах сургалтын байгууллагын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, ЭМЯ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд төгсөлтийн дараах “Эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эмнэлгийн мэргэжилтний тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн тогтолцоо” сэдэвт танилцах аялалыг 2014 онд Швейцар улсад зохион байгуулж, ЭМЯ, БСШУЯ,

тухайн үеийн Эдийн засгийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМШУИС, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, сургалтын эмнэлэг, ТХН гэсэн нийт 9 байгууллагын төлөөлөл болох нийт 15 хүнийг хамруулжээ.

Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 4 үндсэн мэргэшил (дотор, хүүхэд, ерөнхий мэс засал, эх барих эмэгтэйчүүд)-ийн резидентурын сургалтын хөтөлбөрийг сайжруулан, холбогдох байгууллагаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/172 тушаалаар АШУҮИС дээр 2017 оны хичээлийн жилээс эхлэн 3 жилийн хугацаатай туршсан юм.

ЭМСХХ 4, 4+ төслийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв, АХБ-ны төлөөллүүд оролцсон ажлын хэсэг гарч, 2017 оны 1 дүгээр сард шалгуур хангасан 18 эмчээс сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, СХДНЭ-т ажиллах 12 эмчийг сонгож 3 талт гэрээ байгуулан, үндсэн мэргэжлийн 3 жилийн хөтөлбөрт тусгайлан бэлтгэж мэргэшүүллээ.

Хөтөлбөрийн шинэчлэл дээр багагүй туршилт хийсэн бөгөөд 2 жилийн хугацаатай үргэлжилдэг резидентын сургалтыг эмч нарын гардан үйлдэх ур чадвар, практик дадлагыг нэмэгдүүлэх зорилгоор, мөн онолын хичээлүүдийг нэмээд хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай болгож



А. БОЛД

Эрүүл мэндийн салбарын
бодлого, төлөвлөлт,
эмнэлгийн тусламжийн
хөгжлийн бие даасан зөвлөх

"Дэлхийн улс орнуудад 10.000 хүнд ноогдох эмч, сувилагчийн тоогоор эрүүл мэндийн салбарын хүний нөөц хангалттай эсэхийг тодорхойлдог. Монгол улс 10.000 хүнд ногдох эмчийн тоогоороо дэлхийд дээгүүрт жагсдаг бол сувилагчийн хувьд тийм биш. Гэтэл сувилагчид эмнэлгийн тусламж үйлчилгээний дийлэнх хэсгийг гардан гүйцэтгэдэг. Олон улсад дунджаар нэг эмчид 3-5 сувилагч ноогддог бол өнөөдөр манайд 1 эмчид 1.3 сувилагч оногддог. Бид олон эмчтэй ч тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэйгээр үзүүлж чадахгүй байгаа нь эрүүл мэндийн салбарын хүний

нөөцийн бодлого хангалтгүй байгаагийн тод жишээ юм. Түүнчлэн хүний нөөцийг бэлтгэх бодлого сайн хэрэгжээгүйн улмаас ихэнх эмч нар нарийн мэргэжлийн эмч болохыг хүсдэг. Хэвийн харьцаа нь нийт эмч нарын 70 орчим хувь ерөнхий мэргэжлийн, үлдсэн нь нарийн мэргэжлийн эмч нар байдаг бол манайд эсрэгээрээ. Тиймээс энэ асуудлыг бид тулгамдсан асуудал гэж үзэн төслийн бүрэлдэхүүн хэсэгт багтааж, эмч сувилагчийн харьцааг 1:3 болгох, нарийн мэргэжлийн эмч бэлтгэхээс илүү дүүрэг, аймгийн түвшинд, анхан шатанд ажилладаг эмч нарын тоог нэмэгдүүлэхийг зорьсон".

туршсан юм. Улмаар, 2 жилийн хугацаатай суралцаж байгаа 12, 3 жилийн хөтөлбөрөөр суралцаж байгаа 12, нийт 24 эмчийг хамруулсан туршилт судалгааг явуулсан. Мэс заслын хөтөлбөрийн хувьд, 3 жилийн хөтөлбөрийн гол онцлог нь суралцаж байгаа эмч нар осол гэмтлийн үед үзүүлэх лавшруулсан тусламжийн, олон улсын гэрчилгээтэй сургалтыг давхар дүүргэсэн. Нөгөө талаар бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгүүд дээр тохиолддог гол тохиолдлуудаар, тухайлбал цөсний, мухар олгойн үрэвсэл дурангийн мэс заслын чиглэлээр мэргэшиж төгссөн. Үүгээрээ, 2 жилийн хөтөлбөрөөс ялгаатай. Эх барих эмэгтэйчүүд гэхэд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эмчийн удирдлага дор бие даан ажиллаж тэнд нэг хамт олон болж тухайн тасаг дээр урт хугацаагаар ажилласны үндсэн дээр ур чадвараа хөгжүүлэхэд түлхүү анхаарч, суралцаж чадсан.

Түүнчлэн, төслийн хүрээнд АШУҮИС болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зохион байгуулсан үндсэн мэргэшлийн сургалтаар нийт 37 их эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтаар 11 их эмч, сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтаар 43, туслах сувилагч 50-ийг бэлтгэсэн байна.

Анагаах ухааны чиглэлээр дээд боловсролын үйлчилгээ үзүүлдэг сургалтын аливаа



Н.СҮМБЭРЗУЛ

Анагаах Ухааны доктор, профессор

*Анагаахын Шинжлэх Ухааны
Үндэсний Их Сургуулийн
Эрдмийн Сургуулийн Захирал*

“Энэ төслийн хүрээнд хөгжсөн орны жишгээр резидентурын сургалтыг анх удаагаа цалинтай зохион байгуулсан нь өндөр үр өгөөжтэй байсан. Яагаад гэхээр, суралцагч эмч нар маань нэмэлт орлого олох ажил хайж явалгүйгээр сургалтандаа илүү анхаарч аль болох ихийг сурч, эмнэлэг дээр байх цагаа үр ашигтай ашиглая гэж бодож байв. Тийм учраас сургалт үр дүнтэй байсан болов уу”.

байгууллагын хувьд сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээг тогтмол боловсронгуй болгох нь хөгжлийн бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэгжиж буй хөтөлбөрөөр суралцан төгсөх мэргэжилтэн ямар мэдлэг, ур чадвар, хандлагатай байхыг тогтоох, хөтөлбөрийн агуулга, арга зүйг түүнтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг

үнэлэх, дахин сайжруулах ажил нь тасралтгүй хийгддэг эргэх холбоо бүхий процесс тул сургалтын хөтөлбөрт харьцуулсан үнэлгээг хийж үзсэн юм. Үнэлгээний үр дүнд үндсэн 4 мэргэшлийн чиглэлээр 2 ба 3 жилийн хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин (3.2-5.0) дунджаас дээш байсан ба цалинтай суралцах нь сэтгэл ханамжийн түвшинд эерэгээр нөлөөлж байв. Төгсөлтийн онолын болон гүйцэтгэлийн дадлага шалгалтанд

СУРАЛЦАГЧИД БА ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

СУРАЛЦАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН

Сургалтыг цалинтай явуулсанд резидент эмч нарын сэтгэл ханамж өндөр байсан. Энэ нь суралцагсдыг эзэмшвэл зохих үр чадваруудаа өндөр төвшинд эзэмшихэд нь нөлөөлсөн.

СУРАЛЦАГЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАР ЭЗЭМШСЭН ТҮВШИН

Суралцагчид мөн л өндөр үнэлгээ өгсөн. 2 жилийн сургалттай харьцуулахад 3 жил сурсан хүмүүсийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд оролцох давтамж нь олон байсан. Үр дүнд суралцагсдын мэдлэг, ур чадвар нь сайжирсан үзүүлэлттэй байв.

СУРАЛЦАГЧДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Резидент эмч нарын сургалтаар олж авсан мэдлэг ур чадварыг тэднийг ажиллуулсан эмнэлгийн хамт олноос өндөр үнэлгээ авсан.

**Б. ОЮНГОО**

Сувилахуйн сургуулийн захирал




Анагаах Ухааны доктор, профессор

“Энэ үнэлгээний үр дүнгээс үндсэн мэргэшлийн сургалтыг хөтөлбөрийн агуулга, эзэмших цогц чадамж, мэргэжлийн онцлог, чиглэлээс хамааран сургалтын хугацааг тохиромжит байдлаар тогтоож, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд резидент эмч нарын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай эрхзүйн баримт бичиг зэрэг холбогдох асуудлуудыг харгалзаж үзэх хэрэгтэйг олж мэдсэн юм”.

3 жилийн хөтөлбөрөөр суралцан төгссөн суралцагчдын “А” үнэлгээний эзлэх хувь өндөр байсан ($p < 0.05$) ба хөтөлбөрийн агуулгын хувьд дотрын анагаах судлал, эх барих эмэгтэйчүүд судлал, мэс засал судлал, хүүхэд судлал чиглэлээр нарийн ур чадварыг эзэмшүүлж байгаа үндсэн мэргэшлийн сургалтын 3 жилийн хөтөлбөр нь илүү өргөн хүрээнд, орчин үед шаардлагатай эмнэлзүйн гардан үйлдлийн болон багийн ажиллагаа, ёс зүй, хандлага, харилцааны ур чадвар зэрэг хөрвөх ур чадварыг эзэмшүүлж байна гэсэн үр дүн гарсан.

Мөн төслийн хүрээнд, сургалттай уялдуулан суралцагч нарт хэрэгтэй ур чадварыг нь эзэмшүүлэхэд туслах олон улсад ашигладаг гарын авлагуудыг нь бэлтгэж өгсөн. Тухайлбал, олон улсад хэрэглэгддэг хүүхдийн анагаахын чиглэлээр Оксфордын гарын авлагыг сургалтад оролцож байгаа эмч, багш нарт зориулан орчуулж, хэвлэж гаргасан.

Үүнтэй адилаар, эх барих эмэгтэйчүүд судлалын Жон Хопкинсийн их сургуулийн гарын авлага, амбулаторийн, дотрын, анагаах ухааны Вашингтоны гарын авлага гээд олон улсад резидентын сургалтад баримталдаг гарын авлагуудыг АХБ-ны “ЭМСХХ-4” төслийн санхүүжилтээр орчуулж, хэвлэжээ. Эдгээр номуудыг Эрүүл мэндийн шинжлэх ухааны төв



номын сан болон аймаг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын номын санд тарааж, эмч эмнэлгийн ажилтан, багш оюутнууд ашиглаж байна.

Нэмж хэлэхэд, шинэ эмнэлгийн шинэ боловсон хүчнийг бэлтгэж байгаа учраас төслийн хүрээнд эмнэлгийн удирдлагын чиглэлийн сургалтуудыг 2 удаа явуулсан. Нийтдээ 50 гаруй эмнэлгийн удирдах ажилтнууд, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон сургалтууд үр дүнтэй болсон. Эхлээд нүүр тулсан, танхимын хичээлд хамрагдаад дараа нь эмнэлэг дээрээ очиж, олж авсан

онолын мэдлэгээ туршаад, түүний дараа нь дахин танхимын сургалтанд сууж, үлдсэн хичээлүүдээ үзэж дуусгасан. Ийм холимог байдлаар туршлага, онол хосолсон сургалт явуулсан нь суралцагчдад үр дүнгээ өгсөн. Энэ ажлыг АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн Эрүүл мэндийн бодлого менежментийн тэнхим удирдаж, хамтран оролцож ажилласан. Мөн сургалтыг дан ганц АШУҮИС биш Удирдлагын академи, Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан нь хүртээмж, үр дүнг нэмэгдүүлсэн байна.



БҮРЭЛДЭХҮҮН 3:

ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, ХӨТӨЛБӨР 4, 4+





Ж.АЛТАНТУЯА

АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын Нийгмийн салбар хариуцсан ахлах мэргэжилтэн

ЭМСХХ-4 Төслийн бас нэг зорилт нь эмийн аюулгүй байдлыг дээшлүүлэх. Эмийн аюулгүй байдал хүн амын эрүүл мэндэд, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт чухал нөлөөтэй. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо олон байгаа ч үр дүн нь хангалттай биш байгаагийн нэг шалтгаан нь эмийн чанар юм. Эмийн чанар, үр нөлөө муу байгаа нь түүнийг хэрэглэж байгаа хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйгээс гадна эдийн засгийн хохиролтой. Мөн эмийн үнэ өндөр байгаа нь эмзэг бүлгийн иргэдийг ядуусын эгнээнд шилжихэд хүргэж байна. Монголчууд бид бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад үнэтэй эм хэрэглэдэг. Товчхондоо, Монголд эм хангамжийн тогтолцоо, эмийн зохицуулалт хангалтгүй байна. Хэдийгээр бид зах зээлийн нийгэмд амьдарч байгаа ч эм нь арилжааны зүйл биш бөгөөд хүний эрүүл мэнд, улс орны үндэсний аюулгүй байдалд шууд хамааралтай энэ асуудалд зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Тийм учраас олон улсад түгээмэл байдаг эмийн аюулгүй байдлыг хангадаг эмийн зохицуулалтын агентлаг хэмээх хүчтэй байгууллагыг байгуулах, эмийн хяналтыг сайжруулах зорилтыг энэ төслийн хүрээнд гаргаж тавьсан юм.



С.ЦЭЦЭГМАА, профессор

ЭМСХХ-4 төслийн эмийн аюулгүй байдлын асуудал хариуцсан техникийн зохицуулагч (2011-2016 он)

Эм Судлалын Хүрээлэнгийн захирал

ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБЫГ БАЙГУУЛАВ

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 79 тоот тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд 8 хүний орон тоотой Эмийн зохицуулалтын алба байгуулагдсанаар дэлхийн олон орны жишгээр эмийн зохицуулалтын байгууллага байгуулах ажлын эхлэл тавигдсан билээ. Энэ ажил биеллээ олж Засгийн газрын тогтоолоор батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс үйл ажиллагаагаа эхлэн ажиллаж байна.

ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАВ

2014 онд “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн боловсруулж, УИХ-аар батлуулснаас гадна эм хангамжийн байгууллагуудын дагаж мөрдөх үндсэн шаардлага буюу эм үйлдвэрлэл, эмийн түгээлт, хадгалалтад болон эмийн санд тавих ерөнхий шаардлагын улсын стандартуудыг шинэчлэн боловсруулж Стандарт Хэмжил Зүйн Газрын Үндэсний зөвлөлөөр батлуулсан юм.

ЭМСХХ-4 төслийн зөвлөхөөр шалгарсан Английн Оксфорд Менежмент, Нидерландын ХЕРА пүүс, Монголын Гэрэгэ Парнерстай хамтарсан зөвлөх багаас Вилберт Ванненберг, З.Зузаан,




Патрик Хоет, И.Цацрал, Шейла Корт, Л. Тунгалаг, Кеес ван Гроотхеест, Еугене ван Пуиженброек, М.Эрдэнэтуяа нар Эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэх 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт олон улсын болон дотоодын зөвлөхөөр ажиллав.

ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИЙГ ШИНЭЧИЛЭН САЙЖРУУЛАВ

ЭМСХХ-4 төслийн Бүрэлдэхүүн 3 болох “Эмийн аюулгүй байдлыг дэглэмийг сайжруулах” ажлын хүрээнд хүн амд аюулгүй эм хэрэглэх боломжийг үндэсний хэмжээнд нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол улсын Эмийн хяналтын лабораторийг тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагаа, мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх, мэдээллийн технологийг нэвтрүүлэн олон улсын түвшинд нийцүүлэхэд ач холбогдолтой зорилтыг тодорхой үр дүнд хүрч амжилттай хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Нэгдсэн төв лабораторийн барилгыг БНХАУ-ын тусламжаар барьж, 2015 онд ашиглалтанд оруулсан. Тус лабораторийн Эм биобэлдмэлийн хяналтын лабораторийг олон улсын түвшинд нийцүүлэх зорилгоор ЭМСХХ-4 төслийн хүрээнд АХБ-ны санхүүжилтээр ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 1 тэрбум 900 мянга гаруй төгрөгийн 51 төрлийн 118 ширхэг лабораторийн аппарат, тоног төхөөрөмжийг ханган суурилуулж, шаардлагатай урвалж бодисыг нийлүүлсэн.

Төслийн зүгээс лабораторийн техникийн ажилтнуудыг ажлын байран дээр сургах; удирдах ажилтнуудын танилцах аялалыг Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын Эмийн үндэсний



хяналтын чанарын хүрээлэнд зохион байгуулах; эм шинжлэгчдийг Энэтхэг улсын Фармакопейн комиссын лабораторид эмийн шинжилгээний нарийн багаж төхөөрөмж дээр дадлагажуулах сургалтууд, мөн эмийн лабораторийн зохистой дадал (GLP), ISO-17025 стандартын сургалтуудыг зохион байгуулж сургалаа.

Түүнчлэн, лабораторийн олон улсын зөвлөх ажиллаж, олон улсын итгэмжлэлийн урьдчилсан үнэлгээгээр гарсан лабораторийн үл тохирлыг залруулах, лабораторийн шинжээчдийн сургалтын удирдамж боловсруулах, Энэтхэг улсын эмийн хяналтын лабораторитой холбоо тогтоох, лабораторийн удирдлага мэдээллийн тогтолцооны ерөнхий шаардлагуудыг боловсруулахад зөвлөн тусалсан.

Эмийн хяналтын лабораторийн 2013-2016 оны стратеги төлөвлөгөө болон олон улсын ISO/IEC 17025:2005 стандартын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулан хэрэгжүүлэхэд төсөл дэмжлэг үзүүлэн ажилласан. Монгол улсын Эмийн хяналтын лабораторитийн ISO/IEC 17025:2005 стандартын үнэлгээг АНУ-ын Олон улсын итгэмжлэлийн байгууллага буюу ANAB/ ACLASS (American National Accreditation Body) 2015 онд хийж 3 үе шаттайгаар амжилттай хийж гүйцэтгэсэн.

Тус лаборатори энэхүү ISO/IEC стандартын шаардлага хангасныг 2015 оны 12 дугаар сарын 18-нд ANAB-ын итгэмжлэлийн газрын даргын тушаалаар ISO/IEC 17025:2005 стандартаар итгэмжлэлийн олон улсын гэрчилгээг олгосоноор тус лаборатори эмийн

шинжилгээний орчин үеийн аргуудаар Монгол улсдаа төдийгүй бүс нутгийн хэмжээнд эмийн чанарын сорил туршилт хийх цогц чадамжтай болсон.

Ийнхүү ISO стандартын шаардлагыг хангасан Эмийн хяналтын тус лаборатори нь эмийн



шинжилгээний хамгийн орчин үеийн аргуудаар дотоодын болон импортын эмийн чанарыг бүрэн шинжлээд зогсохгүй, бүс нутгийн хэмжээнд эмийн чанарын сорил туршилт хийх цогц чадамжтай болсон. Эмийн хяналтын лаборатори Монгол улсын хүн ам, эмнэлгийн байгууллагуудын хэрэгцээт чанартай, аюулгүй эмийг баталгаажуулах, эмийн зах зээлд хуурамч, стандартын бус эм нэвтрэхээс сэргийлэхэд онцгой үүрэг хүлээж ажиллаж байна.

Түүнчлэн тус лабораторид “Лабораторийн мэдээлэл, удирдлагын тогтолцоо”-г бий болгоход дэмжлэг үзүүлсэн. Төслийн хүрээнд тус лабораторид лабораторийн мэдээлэл, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд 270 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, програм хангамжийг 2016 онд ханган нийлүүлж, ашиглалтанд оруулан дэмжлэг үзүүлэн ажиллаж ирсэн билээ.

ЭМ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИСТОЙ ДАДЛЫН СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАВ

Эмийн үндэсний бодлого, үйл ажиллагааны үндсэн стандартууд (GMP, GDP, GPP)-ыг шинэчлэн батлуулж, эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) стандартын шаардлагын түвшинг дээшлүүлж, үндэсний эм үйлдвэрлэгчид уг стандартын шаардлага хангахад туслалцаа

үзүүлсэний үр дүнд 2021 оны байдлаар 7 эмийн үйлдвэр GMP батламжаа авч, үндэсний эм үйлдвэрлэгчид эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэрэгжүүлж эхэлсэн.

ЭМИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДАРААХ ТАНАДАЛТ, ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨГ БҮРТГЭН МЭДЭЭЛЭХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАВ

Төслийн хүрээнд үндэсний хэмжээнд эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэх гол хэрэгсэл болох эмийн зах зээлийн дараах тандалт, фармаковижилансын үйл ажиллагаа, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тавьж тогтолцоог сайжруулах, мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

Фармаковижилансын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд үнэлэн тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлж, хариу арга хэмжээний тогтолцоог тодорхойлж улмаар залруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг 2019 оны 9 дүгээр сард хийсэн.

Сургалтын хэрэгцээг үнэлж, түүний үр дүнд тулгуурлан эмнэлгийн мэргэжилтнүүд, эмнэлгүүдийн Эмийн эмчилгээний хорооны гишүүдэд зориулан фармаковижилансын сургалтын хөтөлбөр, гарын авлага материалуудыг боловсруулсан. Монгол Улсад

анх удаа “Эмийн гаж нөлөөний менежментийн гарын авлага” гарган, нийслэлийн лавлагаа шатлалын 23 эрүүл мэндийн байгууллагын “Эмийн эмчилгээний хороо”-ны гишүүд, ЭМЯ-ны мэргэжилтнүүд, МХЕГ-ын байцаагч нар, Хүний эмийн хорооны гишүүд зэрэг 50 гаруй мэргэжилтнүүдэд гардуулан өгсөн.

Фармаковижилансын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2013-2014 онд Өвөрхангай, Өмнөговь, Увс, Хэнтий, Дорноговь Дорнод, Төв, Сүхбаатар аймгуудын эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулав. Түүнчлэн бүртгэлтэй Эмийн гаж нөлөөг тогтмол бүртгэн, аюулгүй байдлын тайланг тогтмол шинэчлэн гаргах тухай сургалтуудыг зохион байгуулсан. Эм ханган нийлүүлэх байгууллага, эм үйлдвэрлэгчдэд зориулсан Эмийн аюулгүй байдлын мэдээллийн тайлангийн гарын авлагыг боловсруулж, эм үйлдвэрлэл, бөөний худалдааны салбарт ажиллаж буй 135 эм зүйч нарт сургалт зохион байгууллаа.

Төслийн бас нэг чухал зорилт нь ДЭМБ-ын Эмийн хяналтын төв (WHO Uppsala Drug Monitoring Centre)-ийн гишүүнчлэлийг ханган, бүрэн оролцоог бий болгох байв. Төсөл эмийн гаж нөлөөг мэдээлэх “Vigiflow-first” системийн сургалтыг эхлээд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Эрүүл мэндийн газрын Эмийн

зохицуулалтын хэлтсийн ажилтнуудад, улмаар ЭМЯ-ны холбогдох газар хэлтэс, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн (ЭМХТ) Эмийн зохицуулгын албаны ажилтнуудад танилцуулах ажлыг хийв. 2013 онд Дэлхийн эмийн гаж нөлөөг бүртгэх санд 20 эмийн гаж нөлөөний тайланг оруулснаар Шведийн Уппсала хот дахь ДЭМБ-ын Эмийн гаж нөлөөний хяналтын төвийн бүрэн гишүүнчлэлийг авсан. Фармаковижилансын сургалт болон Эмийн гаж нөлөөний тайлагналтын гарын авлагууд хэвлэгдэн тараагдаж, хэрэглэгдсэний үр дүнд эмийн гаж нөлөөг мэдээлэх тоо 4 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн, ЭМХТ-ийн Эмийн зохицуулах албанаас улсын болон хувийн хэвшлийн 20 эрүүл мэндийн





байгууллагын тайлан, мэдээлэл байдалд хариу зөвлөмж өгөх, эмийн бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудад хариу захиаг илгээх байдал өссөн байна.

Ингэснээр эмийн гаж нөлөөнөөс шалтгаалах сөрөг үр дагавраас сэргийлэхэд онц ач холбогдолтой ажлууд болсон юм.

ЭМЯ-НЫ ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭВ

ЭМЯ-нд эмийн аюулгүй байдлын засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд эм зүйн салбар дахь ил тод байдлын үнэлгээг ДЭМБ-ын Эмийн сайн засаглалын хөтөлбөрийн дагуу хийж, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон “Эм эмнэлгийн хэрэгслийн хууль”-ийн шинэчилсэн найруулгад тусгаж өгсөн.

Тусгай зөвшөөрөл бүхий эм хангамжийн байгууллагууд, эм зүйн салбарын хүний нөөц, улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн гаж нөлөө, зохистой хэрэглээ, эмийн чанартай холбоотой мэдээллүүдийг багтаасан “Эм зүйн салбарын үзүүлэлт”-ийг жил бүр хэвлэн гаргадаг болсон. Түүнчлэн эмийн бүртгэл мэдээллийн LICEMED онлайн программыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан.

ЭМИЙН САЛБАРЫН АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХИЖУУЛАВ

Төслийн энэ бүрэлдэхүүний хүрээнд эмийн зохицуулалт, эмийн хяналт, эм үйлдвэрлэлийн зохистой дадал болон эмийн зах зээлийн дараах танадалт, эмийн бүртгэл мэдээлэл, салбарын эмийн аюулгүй байдлын засаглалын чиглэлээр нийт 23 удаагийн сургалт, семинараар 1300 гаруй мэргэжилтнүүдийг сургалаа.

Гадаад улсад эмийн аюулгүй байдал, эмийн зохицуулалт, эмийн лабораторийн удирдлага, эмийн хяналтын лабораторийн дүн шинжилгээ сэдвээр 4 удаагийн танилцах аялалыг 2014 онд Филиппин ба Вьетнамд, 2015 онд Малайз ба Энэтхэгт зохион байгуулан, нийт 42 мэргэжилтнийг хамруулжээ. Мөн 2014 онд монголын эм үйлдвэрлэл, эм хангамжийн байгууллагуудаар зочлох, дотоодын танилцах аялалд 20 мэргэжилтнийг хамруулав.

ЭМСХХ-4, 4+ ТӨСЛИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ



Ш. ОЮУНБИЛЭГ

*Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт шинжилгээ,
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн*

ЭМСХХ-4, 4+ төслийн Хяналт үнэлгээний хүрээ (DMF)-ний дагуу 3 том зорилтийн хүрээнд 15 үр дүнгийн, 24 үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг 100 хувь амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт 99.3 хувьтай, санхүүгийн зарцуулалт 91.8 хувьтай төслөө амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Монгол улсын засгийн газар ЭМСХХ-4, 4+ төслийг хэрэгжүүлэхдээ тогтвортой санхүүжилт, байгаль орчин, жендерийн тэгш байдал, авилгаас сэргийлэх, гомдол барагдуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр амласан салбарын 9, санхүүгийн 2, нийгмийн хамгааллын 9 болон бусад 3 амлалтуудаа бүрэн биелүүлсэн.

Төсөл АХБ-ны зээл, тусламжийн зарцуулалт, тайлагналтанд тавигддаг бүхий л шаардлагыг хангаж ажилласан. Төслийн ерөнхий төлөвлөгөө

нь эрүүл мэндийн салбарын стратегийн зорилготой нийцсэн, төсөлд хамрагдсан байгууллагуудын институцийн хүчин чадлыг сайжруулсан, олон нийтийн оролцоог хөхүүлэн дэмжсэн, жендерийн мэдрэмжтэй, байгаль орчинд ээлтэй тохиромжит технологийг ашиглаж нэвтрүүлсэн төсөл байлаа. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд гарсан бодлого, эрхзүйн зохицуулалтын орчны өөрчлөлтөд зохицон, үүссэн эрсдэлийг амжилттай даван туулж, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөөг тухай бүрт нь эерэгээр шийдвэрлэсэн.

Төслийн хүрээнд ЭМЯ, хамтрагч байгуулага, салбар дундын ажлын хэсгүүдийг байгуулан, олон талуудын зөвшилцөл оролцоог ханган ажилласан бөгөөд ажлын хэсгийн гишүүдийн 60-80% нь эмэгтэйчүүд байв.

СХД-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, үйлчлүүлэгч иргэдийн

сэтгэл ханамж 2015 онтой харьцуулахад 40 хувиар сайжирсан. Эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжилтнүүдийг чадавхи сайжирч, үндэсний эмийн үйлдвэрүүдэд GMP дадал хэрэгжиж, эмийн зохицуулалтын үйл ажиллагааны 80 хувь нь эерэг үнэлгээ авч, зах зээл дээрх хуурамч, чанаргүй эмийн эзлэх хувь төслийн өмнөх үеэс 2 дахин буюу 11 хувь болж буурсан байна.

Энэхүү төслийн хүрээнд шинээр эхлүүлж хэрэгжүүлсэн, нэвтрүүлсэн ажлуудын цаашдын тогтвортой байдлыг хангах үүднээс тодорхой байгууллагуудад институтчилэн хариуцуулсанаар СХДНЭ, АШУҮИС, ЭМХТ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, МХЕГ-ын Эмийн хяналтын лаборатори зэрг байгууллагууд одоо амжилттай үргэлжилэн хэрэгжүүлж байна.

СУРГАМЖ

Төслийн үйл ажиллагаа батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн ч ЭМСХХ-4,4 + төслийг хэрэгжүүлэх зам шулуун дардан байгаагүй. Хэдий тийм ч ЭМЯ, АХБ, НТХН, гадаад, дотоодын зөвлөхүүд, мэргэжилтнүүд, оролцогч талуудын хамтын хүчин чармайлт, хичээнгүй зүтгэл, чин сэтгэлийн ачаар төсөл амжилттай хэрэгжиж дууслаа. Энэхүү номыг бүтээх болсон нэг зорилго нь төслийн хугацаанд хуримтлуулсан туршлагаа бусадтай хуваалцах юм.

ЭМНЭЛГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМ

Энэ программын хөгжүүлэлтийг цаашид үргэлжлүүлэн, тасралтгүй хийх хэрэгтэй бөгөөд хэрэглэгчдийг байнга сургаж, хэрэглээг дадал болговол эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгө, тоног төхөөрөмжийн төлөвлөлт, ашиглалт, хэрэглээ сайжирч, насжилт нэмэгдэн, цаашлаад эдийн засгийн бодит хэмнэлт гарах боломжтой.

Мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн, хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, алхам тутамд хөгжүүлэх нь нэн чухал бөгөөд уг тогтолцоог

тогтвортой хөгжүүлэх шаардлагатай зардлыг эмнэлгийн төсөвт суулгаж байх нь зүйтэй.

СХДЖНЭ-ИЙН БАГИЙН ЧАДАВХИЖУУЛАЛТ

ОНОК нь олон нийт, иргэдийн оролцоонд суурилсан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн иргэдийн оролцоотой төлөвлөх, шийдвэрлэх арга хэрэгсэлийн нэг бөгөөд төслийн хүрээнд СХДЖНЭ-т анх удаа амжилттай нэвтрүүлсэн. ОНОК нь ижил зорилготой олон талууд нэгдсэн ойлголт мэдээлэлтэй байж, асуудлаа хамтран хэлэлцэн зөвлөлдөж, шийдвэрлэх арга зам хамтаараа гаргаж, тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд танилцуулан уламжлах арга аргачлалаас бүрдэнэ. Олон нийттэй харилцах энэхүү харилцааны хэлбэрийг хөгжүүлсэнээр иргэдийн эрүүл мэндийн байгууллагад итгэх итгэл нэмэгдэж, эмчилгээ, үйлчилгээний чанар, үр дүн сайжирна. Эдгээр аргачлалыг таниулах, сургах, гарын авлагаар хангахад багагүй цаг хугацаа шаардсан хэдий ч тусламж үйлчилгээний төрөл, түүний хүртээмж, чанарыг сайжруулахад иргэд олон нийтийг дайчлан оролцуулах сайн туршлага болсоныг хэлэх нь зүйтэй.

СХДЖНЭ-ИЙН БАРИЛГА УГСРАЛТ

Эрүүл мэндийн салбарт улсын эмнэлгийн барилга угсралтын гэрээг анх удаа олон улсын Фидик гэрээний Ягаан номоор хийсэн. Оролцогч талуудын ойлголт, мэдлэг хангалтгүй байсан тул АХБ-наас Фидик гэрээний төрөл, ангилал, Ягаан номны анхан шатны суурь мэдлэг, мэдээлэл олгох сургалтанд төсөл хэрэгжүүлэх нэгж, ЭМЯ, НХОГ-ын Захиалагч, Зургийн хяналтын инженерүүдийг хамруулж, нэгдсэн нэг ойлголттой болгосон.

Монгол улсын Эмнэлгийн барилга байгууламж барих норм дүрэм хэт хуучирсан, шинэчлэгдээгүй, олон улсын дүрэм журамтай зөрчилддөг. Барилгын зураг төслийг үнэлэх, батлах үндэсний хэмжээний зөвлөх компани байхгүй. Иймд Эрүүл мэндийн сайд болон Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаалаар батлагдсан Барилга угсралтын дэд ажлын хэсгээр барилга угсралтын ажил, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэцтэй холбоотой Европ, Азийн орнуудад хэрэглэдэг стандарт норм журмыг судлан, Монгол улсын дүрэм журамд дүйцэх хамгийн сонгомол хувилбар, гарц шийдлийг хэлэлцүүлэн, мэргэжлийн түвшинд шийдвэр гаргаж ажилласан.

Барилга угсралтын тендерийн үнэлгээний

хорооний бүтэц бүрэлдэхүүн байнга өөрчлөгдөж, хугацаа алдсан хүндрэлтэй үед ЭМЯ-наас АХБ-д хүсэлт тавьж Олон улсын Зөвлөхийг ажиллуулсан, түүнчлэн эмнэлгийн барилгын газрын зөвшөөрлийг зэргэлдээх орон сууцны барилгатай давхардуулан олгосонтой холбоотойгоор шинэ эмнэлгийн барилгыг шилжүүлж, газар доорхи инженерийн шугамыг зөөхтэй холбоотой гарсан төлөвлөгдөөгүй ажлын нэмэлт зардал болон эмнэлгийн орц гарц зогсоолыг барихтай холбоотой гарсан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг төслийн баг, ЭМЯ, АХБ, нийслэлийн засаг захиргааны багийн хамтын хүчээр амжилттай шийдвэрлэсэн.

АХБ-ны санхүүжилтээр эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн ЭМСХХ 4, 4+ төслийн амжилт нь төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын хүчээр ихийг бүтээн байгуулах боломжтойг харуулж чадсанаараа онцлогтой.

Төсөл анх төлөвлөж байсан хугацаанаасаа багагүй хугацаагаар хойшилсонд улс төр, засгийн газрын тогтворгүй байдал, төр, захиргааны зарим байгууллагуудын хүнд суртал, ажлын уялдаа холбоо, залгамж чанар сул байсан нь ихээхэн нөлөө үзүүлсэн гэдгийг дурдах нь зүйтэй.

ЭМСХХ-4, 4+ ТӨСЛИЙН ҮР АШИГ ХҮРТЭГЧИД

ЭМСХХ-4, 4+ төслийн үр ашгийг хүртэх гол хүмүүс бол эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, эм хэрэглэх шаардлагатай иргэд юм. Төслийн үр

дүнд, тэд чанартай үйлчилгээ авч, эм хэрэглэж, чадварлаг эмчээс зөвлөгөө авна. Төслийн зарим нэг үр ашиг хүртэгчдийн сэтгэгдлийг толилуулъя.

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН 1: ДҮҮРГИЙН ЖИШИГ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ БАРИХ



Ц.ОЛОНБАЯР

СХДЖНЭ-ийн Дарга

АХБ болон Монгол улсын Засгийн газрын санхүүжилттэйгээр, ЭМСХХ-4, 4+ төслийн хүрээнд орчин үеийн эмнэлгийн зориулалт бүхий европ стандартын инженерийн шийдэл бүхий жишиг нэгдсэн эмнэлэг ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлснээр дүүргийн төдийгүй Монгол улсын эрүүл мэндийн салбарт томоохон дэвшил гарсан.

Өмнө нь Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв болон нэгдсэн эмнэлэг нь насанд хүрэгчдийн болон хүүхдийн тусламж үйлчилгээг дагнасан байдлаар тус тусдаа явуулж байсан бол жишиг нэгдсэн эмнэлэг ашиглалтад орсноор 264 нэр төрлийн 1133 ширхэг тоног төхөөрөмж бүхий поликлиникийн, 27 кабинет, 365 хэвтэх ор, 280 эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүхий баг хамт олон нэг өдөрт Сонгинохайрхан дүүргийн төвийн болон Толгойт бүсийн нийт 175 хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх боломж бүрдсэн.

Орчин үеийн чанар стандарт, аюулгүй байдлыг хангасан барилга байгууламж, сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи бүхий чадварлаг хүний нөөцтэй жишиг нэгдсэн эмнэлгийг Монгол улсад анх удаагаа барьж өгсөн төсөл



Б.ГАЛСАНЦЭДЭН

СХДЖНЭ-ийн Зөвлөх эмч

2003-2021 оны хооронд СХДЖНЭ-ийн даргаар ажиллаж байсан

Би олон эмнэлэг ашиглалтад орж байхыг харсан. Тоног төхөөрөмж болон хүний нөөцийг нь бэлдээд, байрыг нь европ стандартаар барьсан эмнэлэг бол миний мэдэж байгаагаар л анхных нь манай эмнэлэг. Өмнө нь бид эмнэлгийн байр

хэрэгжүүлэгч баг хамт олон, Монгол улсын Засгийн газарт, Сонгинохайрхан дүүргийн 332.000 ард иргэд болон нэгдсэн эмнэлгийн нийт эмч, сувилагч, ажилтан ажиллагсдын өмнөөс баярласан талархсанаа илэрхийлж байна.

байрчихаад “эмнэлгийн шинэ байртай боллоо” гэж ярьдаг байсан. Харин өнөөдөр бид байртай биш бүхэл бүтэн эмнэлэгтэй боллоо.

Сонгинорхайрхан дүүргийн шинэ эмнэлэг ашиглалтад орсноор эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж эрс сайжирч, 3 дугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний нэг хэсгийг нь бие даан үзүүлэх боломжтой боллоо.

Эмнэлгийнхээ 2 жигүүрт корона вирусийн халдвартай хүмүүсийг хүлээн авч эмчилж байгаа хүнд цаг үед би энэ ярилцлагыг өгч байна. Манай эмнэлэг 250 ортой. Ор бүрт нь 100% хүчилтөрөгч хангамжийн үзүүр бий. Эмнэлгийн гадаа хүчилтөрөгчийн 110 баллон бүхий нөөцтэй. Хорь гаруй хиймэл амьсгалын аппарат ажиллаж байна.

Төслийг санхүүжүүлэгч АХБ, Монгол улсын Засгийн газар, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд гар бие оролцсон бүх хүмүүстээ чин сэтгэлийн угаас талархаж байна.



Д. СҮНЖИДМАА

СХДЖНЭ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Би ажлын гараагаа 1999 онд хэсгийн эмчээс эхлэн эмнэлэгтээ тасралтгүй 20 гаруй жил ажиллаж байна.

Өмнө нь бид өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийг 3 дугаар шатлалын болон хувийн

эмнэлгүүд рүү илгээдэг байсан бол одоо олон тооны тусламж үйлчилгээг эмнэлэгтээ үзүүлж чаддаг боллоо. Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээний хувьд, 1 өдөрт дотор мэдрэлийн тусламж үйлчилгээг 145 хүнд, нээлтээ хийснээс хойш сэргээн засах тусламж үйлчилгээг 95 хүнд, мөн ор, хоног эзлэхгүйгээр өдрийн мэс заслын тусламж үйлчилгээнд 50 гаруй хүн үзүүлээд байгаа (2021 оны 9 дүгээр сарын байдлаар) бөгөөд үүний үр дүнд, 90 гаруй сая төгрөгийн орлогыг эмнэлэгтээ орууллаа. Бидний үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, иргэдэд хүрэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, чанар нь сайжирч байгаагийн үр дүнд эмнэлэг тогтвортой ажиллах санхүүгийн боломж нээгдэж байна.

Эмнэлэг маань ашиглалтад орсноороо эмнэлгийн эмч ажилчид өөрсдийгөө хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвараа сайжруулах таатай орчин нөхцөл бүрдээд байна. Амь тэмцсэн үеийн болон сувилахуйн тусламж үйлчилгээний сургалтанд хэрэглэгдэх 29 нэр төрлийн 38 ширхэг сургалтын мулеж бүхий кабинеттай болсон.

Манай СХД гэр хороолол ихтэй, эмзэг ядуу бүлгийн хүмүүс дийлэнх хувийг эзэлдэг. Хөдөө орон нутгаас ирсэн, бичиг баримтгүй олон иргэд тусламж үйлчилгээ авч чадахгүй хоцордог байсан бол эрүүл мэндийн даатгалын санхүүжилт

гүйцэтгэлд тулгуурлан олгогдох эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор иргэн эрүүл мэндийн даатгалаа төлсөн л бол шаардлагатай тусламж үйлчилгээг манай эмнэлгээс цогцоор нь авах боломж бүрдсэн.

Ийм сайхан орчинд, сайн тоног төхөөрөмжтэй, чадварлаг хүний нөөц бүрдүүлээд ажиллаж байгаадаа эмч хүний хувьд маш их баярлаж байна.

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН 2: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ



Н. МИНЖМАА

СХДНЭ-ийн Дүрс оношилгооны эмч, дүрс оношилгооны тасгийн эрхлэгч

2016-2018 онд АХБ-ны санхүүжилттэй “ЭМСХХ 4” төслийн тэтгэлэгт сургалтын төгсөгч

Онол болон практикийн дадлага туршлагыг хослуулсан энэ сургалт надад үнэхээр үр өгөөжтэй байсан. Эзэмшсэн мэргэжил, дур сонирхолтой мэргэшлээ улам чанаржуулахын зэрэгцээ түүгээрээ шууд ажиллах боломж бүрдсэнд би их баярладаг. Би ур чадвараа нэмэгдүүлж, миний карьерт өсөлт гарсан.



А. БЯМБАСҮРЭН

СХДНЭ-ийн Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн сувилагч

Би 2014 онд тус эмнэлэгт сувилагчаар орж байсан. 2020-2021 онд эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн чиглэлээр сурсан. Эрчимт эмчилгээний хувьд, ихэвчлэн хүнд өвчтөнтэй харьцдаг учраас тэр хүнтэйгээ илүү тулж харьцдаг. Тийм учраас ур чадвар маш сайн байх ёстой гэж би боддог. Дээрээс нь өвчтөнийхөө амин үзүүлэлтийг цаг тутамд хянадаг учраас өвчтөнөө мэдрэх, түүнийгээ эмчдээ мэдээллэхээс авахуулаад өндөр ур чадвартай байх ёстой. Хүний амь насыг аврахтай холбоотой чиглэлээр ажиллах учраас илүү ур чадвар шаарддаг, гардан гүйцэтгэдэг ажлуудыг сургалтанд сууснаар хийж сурсан.



Д. НАРАНТУНГАЛАГ

СХДНЭ-ийн Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн туслах сувилагч

Би энэ эмнэлэгт ажилд ороод 4 жил гаруй болж байна. Одоо туслах сувилагчийн сургалтад сууж байгаа юм. Энэ сургалтыг төгссөний дараа хүнд анхны тусламжийг бүрэн гүйцэд өгч чадах хэмжээний ур чадвартай болно гэдэгтээ итгэлтэй байна. Өөрийнхөө мэдлэгийг дээшлүүлж, мэдэхгүйгээ мэдэж авах гэж энэ сургалтад суусан. Сувилагч хүн ямар байх ёстой, юуг мэдэж, чаддаг байх ёстой тэр бүгдийг л мэдэж авах гээд хичээж байна. Хэрэгтэй зүйл их сурч байгаа болохоор энэ сургалт таалагдаж байна.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ



Ц. АЛТАНЦЭЦЭГ

"Мөнхийн тун" эмийн үйлдвэрийн Ерөнхий захирал

2004 байгуулагдсан манай үйлдвэр ЭМСХХ-4, 4+ төслийн хүрээнд эмийн үйлдвэрийн зохистой

дадлын GMP стандартыг хангах, GMP шинжээч бэлдэх хөтөлбөрт хамрагдаж, GMP-ийн стандарт гэж юу болох, GMP-тэй эмийн үйлдвэрт ажиллах мэргэжилтнүүд ямар шаардлага, шалгуурыг давсан байх, тэднийгээ яаж сургах тухай мэдэж авсан. Улмаар, эмийн үйлдвэр маань 2019 онд GMP-тэй болсон. Эдгээрийн үр дүнд, манай эмийн үйлдвэрийн хүний нөөцийн чадавхи сайжирсан. Дагаад, эмийн бүтээгдэхүүний чанар сайжирч, бас бүтээгдэхүүний нэр төрөл олширсон. Салбараар нь харвал, Монгол эмийн компаниуд GMP шаардлага хангаснаар олон улсад үйлдвэрлэгдсэн, импортоор орж ирдэг эмүүдтэй ижил чанартай бүтээгдэхүүн Монголчууд хэрэглэх боломж бүрдлээ гэсэн үг. Одоо бид Монгол улсын болон цаашлаад олон улсын GMP шаардлагыг хангаж, өөрсдийн үйлдвэрлэдэг эм болон комбинзон, халаад малгай, маск гэх мэт бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд гаргах боломж бүрдэх юм.



Б.ЭНХЗАЯА

“Монос” эмийн үйлдвэрийн Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал

Төслийн ачаар, манай Монос Фарма үйлдвэрийн шинэ байраа ашиглалтад оруулахтай зэрэгцээд GMP батламжаа авсан. Бид олон улсад бүтээгдэхүүнээ гаргадаг экспортын компани болох зорилго тавин ажилладаг бөгөөд ингэхийн тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагуудаар батламжлуулахад чанарын удирдлагын тогтолцоо, эм үйлдвэрлэлийн зохистой дадал, GMP стандартууд маш сайн хөрс суурь болж өгч байна. Өнөөдөр, бид Канадад төвтэй Паск гэдэг байгууллагаар чанарын удирдлагын тогтолцоогоо итгэмжлүүлээ. Тун


удахгүй лаборатори болон эмийн үйлдвэрээ олон улсын GMP шаардлага хангасан үйлдвэр болгох гээд зорьж ажиллаж байна. Монгол улс нийт эмийнхээ 80-85 хувийг гадаадаас авдаг. Дотоодын эмийн үйлдвэрүүд GMP шаардлага хангана гэдэг нь гадаадын нэртэй пүүсүүдтэй яг адилхан орчин нөхцөлд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болсон гэсэн үг. Хэдий олон эмийн үйлдвэр энэ шаардлагыг хангана төдийчинээ Монгол хэрэглэгчдэд хэрэгтэй.



Г.ТАЙВАНБАТ

“Нахиа” эмийн үйлдвэрийн дарга

Энэ төсөлд хамрагдсанаар бид үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалтаа өөрчилж, ажилтнуудаа сургаж, мөн олон улсын зөвлөхүүдтэй хамт ажилласан. Улмаар, манай эмийн үйлдвэр 2007, 2014, 2017 онуудад үе шаттайгаар GMP стандартуудыг нэвтрүүлсэн. Бид Үйлдвэрийн



Б.ХУВЬТАВИЛАН

*Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа
лабораторийн Эмийн хяналтын лабораторийн эрхлэгч*

Шинжлэх ухаан, техник технологи хөгжиж дэвшихийн хэрээр эмийн шинжилгээний аргууд

баталгаажилтын болон Эмийн хөгжүүлэлтийн албыг шинээр байгуулж бүтээгдэхүүний чанар, бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ сайжруулсан. Бид одоо БНХАУ-д бүтээгдэхүүнээ экспортлох зорилготойгоор судалгааны ажил хийж байна.

ч мөн нарийсч сайжирч байдаг. Төслийн хүрээнд манай лаборатори Монгол улсдаа байгаагүй шинэ багаж, тоног төхөөрөмжүүдтэй болсоноор дэлхийн жишигт нийцсэн шинжилгээг хийж чаддаг болсон. Үр дүнд нь эмийн зах зээлийн 75 хувийг импортын бүтээгдэхүүн эзэлдэг Монгол улсын иргэд баталгаатай, чанартай эм, эмийн бүтээгдэхүүнийг эргэлзэлгүй хэрэглэх боломж бүрдлээ.

Манай лаборатори үндэсний итгэмжлэлд 4 жилд нэг удаа, Америкийн Нэгдсэн улсын итгэмжлэлийн үндэсний байгууллагаар жил болгон шалгуулдаг улсдаа ганц эмийн лаборатори юм. Манай лабораторид 21 аймгаас шалтгаантай дээжүүд, дотоодын 30 гаруй эмийн үйлдвэрүүдийн шинэ бүтээгдэхүүний чанарын хяналт, экспортод гаргах хүнсний аюулгүй байдлын шинжилгээ хийгддэг. Тиймээс, бидний чадавхи сайжрах нь энэ бүгдэд дэвшил авч ирж байгаа билээ.



Ц.ШҮР

Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн Чанарын менежер

Энэ төсөл манай байгууллагад 2011-2015 оны хооронд 4 жилийн хугацаанд хэрэгжихдээ, 1,1 сая долларын багаж тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж үзүүлж, дээр нь манай

байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах сургалтууд хийгдсэн. Хамгийн гол нь манай лабораторийг олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдэх, чанарын удирдлагын ISO17025 стандартыг нэвтрүүлэхэд дэмжиж тусласан. Манай эмийн хяналтын лаборатори олон улсын түвшинд итгэмжлэгдсэний үр дүнд, манай ажилтан албан хаагчдын мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, бичиг баримт хөтлөлт нь англи, монгол 2 хэл дээр явдаг манай лабораторийн ажилтнуудын англи хэлний мэдлэг, чадвар эрс дээшилсэн. Зохион байгуулсан сургалтуудын ачаар олон улсын түвшинд хүрсэн дэвшилтэт арга, аргачлалуудыг шинжилгээндээ тасралтгүй нэвтрүүлдэг боллоо. Олон улсын түвшинд хүрсэн чанарын удирдлагын тогтолцоо бүхий итгэмжлэгдсэн лабораторитой, түүгээрээ эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнүүдийн шинжилгээг хийх, хянах боломжтой болно гэдэг нь хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд эерэг нөлөөтэй, чухал ач холбогдолтой ажил болж чадсан гэж бодож байна.



Ш.ЭНХТУЯА

*Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын
Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах
байцаагч*

Бидний ажил үүрэгт эмийн үйлдвэрүүдийн хяналт шалгалт багтдаг. Төслийн хүрээнд эм үйлдвэрлэлийн зохистой дадлын чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч нарыг чадавхжуулах, онолын сургалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Мөн олон

улсын GMP зөвлөх Монгол улсад ажиллаж, улсын байцаагч нарыг эмийн үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх дадлага ажлыг хамт хийснээр улсын байцаагч эм үйлдвэрлэлийн зохистой дадлын хяналтыг мэргэжлийн өндөр түвшинд хийх мэдлэг, ур чадвартай болсон. Мөн Монгол улсад хийгдэж байгаа хяналт шалгалтын үйл ажиллагаанд төслийн зөвлөхүүд үнэлгээ хийж, хэрэгжүүлэх шаардлагатай ажил, анхаарах асуудлуудын талаар зөвлөгөө өгсөн. Мөн улсын байцаагч нарын хэрэглэдэг стандартууд болон журмын жагсаалтууд, олон улсын эмийн хяналтын зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаа зэрэг мэдээллүүдийг агуулсан хяналтын байцаагч нарт зориулсан гарын авлагыг санхүүжүүлж, хэвлүүлсэн. Түүнчлэн, мэргэжлийн хяналтын байгууллагын системд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх анхан шатны мэдээлэл олгох сургалтыг улсын байцаагч нарт болоод байгууллагын удирдлагуудад хийсэн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхөд чухал нөлөө үзүүлсэн. Бид GMP стандартуудыг нэвтрүүлсэн дотоодын эмийн үйлдвэрүүдийг эм үйлдвэрлэх зохистой дадлаа бүрэн дүүрэн мөрдөж буй эсэхт хяналт шалгалт тогтмол хийдэг.

ТАЛАРХАЛ

Энэхүү номын агуулгыг боловсруулахад гүн туслалцаа үзүүлсэн дараах хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Н.ОЮУНБИЛЭГ

ЭМСХХ-4 төслийн Эмнэлгийн хөгжлийн асуудал хариуцсан менежер

Ш.ОЮУНБИЛЭГ

НТХН-ийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Б. АЛТАНЦЭЦЭГ

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүний нөөц, төлөвлөлт, зөвлөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн гэж засах

Э.БОЛОР-ЭРДЭНЭ

НТХН-ийн ЭМСХХ төслийн Гэрээ хариуцсан менежер

Н.БЯМБАСҮРЭН

НТХН-ийн ЭМСХХ 4 төслийн Гэрээ хариуцсан менежер

М.МАРГАД

ЭМСХХ 4 төслийн санхүүгийн ажилтан

Х. ЧУЛУУНБААТАР

НТХН-ийн ЭМСХХ 4 төслийн Барилгын хяналтын инженер

А.ЮМЧМАА

НТХН-ийн ЭМСХХ-4 төслийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын мэргэжилтэн

Ж.БАЯРТОГТОХ

НТХН-ийн ЭМСХХ 4 төслийн Тоног төхөөрөмж худалдан авалт хариуцсан мэргэжилтэн

М.ТОГТУУНБАЯР

Эрүүл Мэндийн Хөрөнгийн Төлөвлөлтийн программыг бүтээгч, Multitech ХХК-н Захирал

Г. ЦЭЦЭГДАРЬ

ОНИЗБ-ийн ахлагч, олон нийтийг идэвхжүүлэх зөвлөх багийн Ахлагч

Ц.МӨНХДЭЛГЭР

Сэтгүүлзүйн шинжлэх ухааны магистр, Олон нийтийг идэвхжүүлэх зөвлөх багийн Олон нийттэй харилцах зөвлөх

Б.БАТЦООЖ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, судалгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Г.УРАНЧИМЭГ

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн дотоод хяналтын мэргэжилтэн

П.БАТ-ИРЭЭДҮЙ

СХДНЭ-ийн ашиглалтын өмнөх захиргааны даргаар ажиллаж байсан

СХДНЭ-ийн Бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга

М.АРИУНЖАРГАЛ

Вамед Инженеринг ГмбХ Төлөөлөгчийн Газрын Захирал

Л.ХАНДСҮРЭН

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн сургалт, олон нийтийн харилцааны мэргэжилтэн

Б. ЦЭНД-АЮУШ

НТХН-ийн барилгын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР:

Төслийн вэбсайт: www.hsdp.org

Төслийн фэйсбүүк хуудас: Эрүүл Мэндийн Салбарын Хөгжил Хөтөлбөр

Төслийн юүтүб хуудас: Health Sector Development Project

Төслөөс эрхлэн гаргасан ном, товхимолууд:

1. Эх барих эмэгтэйчүүд судлалын гарын авлага
2. Хүүхдийн анагаахын Оксфордын гарын авлага
3. Амьсгалын эрхтэний эмгэг судлал
4. Амбулаторийн дотрын анагаах ухааны Вашингтоны гарын авлага
5. Олон нийтийн онооны картаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх нь
6. Эм хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж
7. Антибиотикийн зохистой хэрэглээ /өврийн дэвтэр/

